



ЭРДЭМ

СОЁЛЫН ЖИМЭЭР
THE CULTURAL WAY

ШИНЖИЛГЭЭ



Эрхэлсэн: Э.Итгэл

ISSN: 2791-1446

© Sodon Soyod Publishing, Mongolia



СОЁЛЫН ЖИМЭЭР
THE CULTURAL WAY

ISSN: 2791-1446

БОТЬ X (№2)

Редакцын зөвлөл:

Доктор (Sc.D)	Д.Бадамдорж	(Монгол)
Доктор (Ph.D)	Л.Чулуунбаатар	(Монгол)
Доктор (Ph.D)	Л.Хурцбаатар	(Герман)
Доктор (Ph.D)	Цолмон	(БНХАУ)
Доктор (Ph.D)	Бао Ургаацэцэг	(БНХАУ)
Доктор (Ph.D)	Н.Мягмар	(Монгол)
Доктор (Ph.D)	Л.Хасбаатар	(БНХАУ)
Доктор (Ph.D)	Б.Болд	(Япон)
Доктор (Ph.D)	Залгаабаяр	(БНХАУ)

“СОЁЛЫН ЖИМЭЭР” Соёл Судлалын Төвийн

Эрдэм шинжилгээний редакцын зөвшөөрлөөр хэвлэх, улирал тутмын сэтгүүл

Улаанбаатар 2024

ISSN: 2791-1446

© Sodon Soyod Publishing, Mongolia



СОЁЛЫН ЖИМЭЭР
THE CULTURAL WAY

ISSN: 2791-1446

VOLUME X

Editorial board:

Doctor (Sc.D)	Badamdorj. D	(MGL)
Doctor (Ph.D)	Chuluunbaatar. L	(MGL)
Doctor (Ph.D)	Qurčabaatar. L	(GER)
Doctor (Ph.D)	Tsolmon	(PRC)
Doctor (Ph.D)	Bao Urgaatsetseg	(PRC)
Doctor (Ph.D)	Myagmar. N	(MGL)
Doctor (Ph.D)	Qasbaatar. L	(PRC)
Doctor (Ph.D)	Bold. B	(JAP)
Doctor (Ph.D)	Zalgaabayar	(PRC)

Edited by: Itgel. E

THE CULTURAL WAY
CENTER FOR CULTURAL STUDIES
Printed with permission of editorial board
a quarterly journal of research
Ulaanbaatar 2024

ISSN: 2791-1446

© Sodon Soyod Publishing, Mongolia



СОЁЛЫН ЖИМЭЭР THE CULTURAL WAY

ГАРЧИГ

1. Л.Чулуунбаатар ӨВӨР МОНГОЛ ДАХЬ КИРИЛЛ ҮСГИЙН СУРГАЛТ.....	1
2. Жао Хашэнь Гаова ЯПОН ХЭЛНИЙ ОЛОН УТГАТ ҮЙЛ ҮГ “上がる” -ИЙН УТГЫН ӨРГӨЖЛИЙН ТАНИН МЭДЭХҮЙН СУДАЛГАА.....	13
3. Залгаахүү МОНГОЛ ХЭЛНИЙ ҮГСИЙГ ХЭРХЭН АЙМАГЛАХ БА УХАГДАХУУНЧЛАХ ТУХАЙ ХАРЬЦУУЛАН ШИНЖЛЭХ НЬ.....	20
4. Эрдэнэ, Лю Чүньши ЛУВСАНДАНЗАНЫ “АЛТАН ТОВЧ” ДАХЬ БУРХНЫ ШАШНЫ НӨЛӨӨ ТУСГАЛЫГ ШИНЖЛЭХ НЬ.....	29
5. Аруухан ХӨХНУУРЫН ЧУУЛГАНЫ ЦААЗЫН БИЧИГ ХИЙГЭЭД САЙН ҮГТ ЭРДЭНИЙН САН НЭРТ ШАСТИР-ТАЙ ТОХИРОЛЦОХ ХЭСГИЙН ҮСГИЙН БИЧЛЭГИЙГ ХАРЬЦУУЛАН ШИНЖЛЭХ НЬ.....	39
6. Гоёонч ДУЛААНЫ ӨГҮҮЛЛЭГ ДЭХ “ЗОЛИОСНЫ ХОНЬ 替罪羊” ГЭХ УР ЗАГВАРЫН ТАЙЛАЛ.....	50
7. Уяхан ИЛ ХАНЫ ХАТДЫН “injū”-ИЙН ТУХАЙ.....	59
8. Бао Линлин ЧИНГИС ХААНЫ ХУУЛИЙН СҮВЭГЧЛЭЛ ХИЙГЭЭД СУДАЛГААНЫ ШИНЭ ХАЙЛТ.....	74



СОЁЛЫН ЖИМЭЭР THE CULTURAL WAY

CONTENT

1. Chuluunbaatar. L
Cyrillic training in Inner Mongolia
2. Zhao Hashen Gaowa
A cognitive study on the semantic expansion of the Japanese polysemous verb “上がる”
3. Zalagahu
A comparative analysis of how to predict and conceptualize Mongolian words
4. Liu Chunxi
Analyzing the influence of religion on The Lu. Altan tobči
5. Aruhan
Comparative analysis of the transcripts of the words in agreement between the two sources
6. Goyonchi
An interpretation of the scapegoat concept
7. Uyihan
About the "injū" of Il khanate queens
8. Bao Lingling
Genghis Khan legal analysis and new research



СОЁЛЫН ЖИМЭЭР THE CULTURAL WAY

ЭРХЛЭН ХЭВЛҮҮЛЭГЧИЙН ҮГ

Энэ удаагийн дугаарт Монголын Үндэсний Их Сургууль, Өвөр Монголын Их Сургууль - Монгол Судлалын Дээд Сургууль, Хаалган хот дахь Удирдлагын Сургууль, Хө Тао Дээд Сургууль зэрэг эрдэм шинжилгээний байгууллагуудын эрдэмтэн багш, докторант, магистрантуудын өгүүллүүд багтав. Эрдэм шинжилгээний үйл хэргийг чин сэтгэлээсээ дэмжин, зөвлөгөө шүүмжээ харамгүй хайрладаг номын садан, нөхөддөө машид талархлаа. Аливаа судалгааны ажил бүхнийг хүч хөдөлмөр, хөрөнгө санхүүгүйгээр төсөөлөхийн аргагүй билээ. Тус дугаарыг хэвлүүлэхэд онцгойлон дэмжлэг үзүүлсэн судалгааны төвийн нийт гишүүддээ чин сэтгэлийн талархал дэвшүүлье.

Эрдэнэхуягийн Итгэл

2024 оны 5 сарын 30

НОМЫН ЦАГААН БУЯН ДЭЛГЭРЭХ БОЛТУГАЙ

ISSN: 2791-1446

© Sodon Soyod Publishing, Mongolia



ӨВӨР МОНГОЛ ДАХЬ КИРИЛЛ ҮСГИЙН СУРГАЛТ

Л.Чулуунбаатар*

Дэлхий дахинаа багцаа тоогоор 10 сая орчим монголоор ярьдаг монгол үндэстэн оршин амьдарч байна хэмээдэг. 2015 онд Монгол улсын засгийн газар хүн амынхаа тоог 3 сая болсоныг албан ёсоор зарлан тунхагласан билээ.¹ 2010 оны байдлаар ӨМӨЗО-нд 4.5 сая монгол үндэстэн, Хөх нуур, Шинжааны монголчуудыг нийлүүлээд 5 сая гаруй монгол үндэстэн байна.² 1932 он хүртэл нийт монгол үндэстнүүд бүгд монгол бичгийн хэлтэй байсан бөгөөд 1936 оноос Буриад, Халимагууд кирилл үсэгт, 1941 оноос Монгол улсын монголчууд кирилл бичигт шилжин орж, БНХАУ-ын өвөрмонголчууд монгол бичигтэйгээ үлдэж, Шинжааны монголчууд тод бичгээ 1988 онд монгол бичиг болгон сольсон билээ. Энэ нь Өвөрмонголын соёл боловсрол, утга урлагаас суралцах, Шинжааны монголчууд ерөнхий боловсролын сургуулиа төгсгөөд шууд ӨМӨЗО-ны их, дээд сургуулиудад шууд орж суралцахад нь амар хялбар болсон байдаг. Гэвч 1970 он хүртэл монголчууд монгол бичиг, кирилл, тод үсгийн гурван хэлбэр хэрэглэж, гурван улсад хуваагдан амьдарч байсны улмаас 12 саланга хэл аялгуунд хуваагдан аялгууны зөрөө үлэмж их болсон байна. Монгол бичиг бол мянга гаруй жил монгол үндэстнүүд бичиг соёлдоо хэрэглэж, монгол хэлний салшгүй нэгэн амин сүнс болсоны хувьд Монгол улсын монголчууд 1980-аад оны сүүлээс монгол бичгээ сурч эзэмших, улмаар төрийн бичиг болгохыг эрмэлзсээр байгаа боловч 70 гаруй жил кирилл бичгээр сурч, бичиж, уншин дадал, хэрэгцээгээ болгон ирсэн тул Монгол улсын хүн амын дийлэнх нь монгол бичгийн бичлэгийн зөрүү, хоёр бичгийн дүрмийн зөрүү зэргээс болоод сурахад тохиолдох бэрхшээлд зориг шантран төрийн бичгээ болгох шийдвэр ихээхэн саармагжин бүдгэрсээр байна. Үүний улмаас Монгол улсаас ерөнхий болосролын дунд сургууль төгсөөд юм уу магистер докторын

* Монгол Улсын Үндэсний Их Сургуулийн профессор

¹ https://newmedee.blogspot.com/2015/01/3_21.html

² https://mn.wikipedia.org/wiki/Өвөр_Монголын...



THE CULTURAL WAY

сургалтад ӨМ-ийн Их, Дээд сургуульд суралцахаар одогсод заавал нэг жил монгол бичиг сурах хэрэгтэй болж сургалтын хугацаа уртасахад хүрдэг. Монгол улс монгол бичигтэй байсан бол илүү нэг жилийн хугацаа шаардагдах хэрэгцээгүй болохсон билээ. Гэхдээ энэ 70 гаруй жилийн хугацаанд кирилл бичиг Монгол улсын соёл боловсрол, шинжлэх ухааныг хөгжүүлэх, цэцэглүүлэх гол зэвсэг болсоны хувьд дэлхий дахины монголчууд Монгол улсын монгол хэл соёл, шинжлэх ухааны ололтоос сурах судлах хүсэл эрмээлзэлийн бичиг болсоор ирсэн билээ. БНХАУ байгуулагдсаны дараа ӨМӨЗО-ны өвөрмонголчууд 1952-1954 оны хооронд БНМАУ-ын монголчуудтайгаа адил бичигтэй болж хэл соёлоо адилаар хөгжүүлэхийг эрмэлзэн кирилл бичиг сурах хөдөлгөөн өрнүүлж эхэлсэн байдаг юм. Гэвч кирилл бичгийн зөв бичих дүрмийн цэгцгүй байдал хийгээд Хятадын засгийн газрын шийдвэрийн дагуу монгол бичгээ хэвээр үргэлжлүүлэн хэрэглэж, одоо болтол соёл боловсролоо хөгжүүлсээр байна. Орчин үед Монгол улс болон БНХАУ-ын хооронд хамтын ажиллагааны өргөн хэмжээний түншлэл бий болж, бүх талын стратегийн түншлэлийн гэрээ байгуулсаны улмаас улс хоорондын гадаад харилцаа, хил гааль, ажил хэрэг, бизнесийн үйл хэрэгт монгол бичиг, кирилл бичгийн боловсролтой хүний хэрэгцээ нэн их шаардлагатай болсон байна. Тийм болохоор БНХАУ-ын Төвийн үндэстний дээд сургууль болон ӨМИС-ийн МСДС-иудад 2011 оноос Кирилл бичгийн тусгай анги байгуулан кирилл, монгол бичгийн мэргэжилтэн бэлтгэх ажлыг хүч тавин хэрэгжүүлж байна. Цаашлавал Хөлөн буйрын Их сургуульд кирилл үсэг сурах анги байгуулах зэргээр хүрээгээ тэлж байна. Кирилл бичиг нь орчин цагийн монгол хэлний ярианы хэлэнд суурилж, ихэнх тохиолдолд бичлэг дуудлага адил байхын улмаас өвөрмонголчууд кирилл бичиг сурахад монгол улсын монголчууд монгол бичиг сурахаас арай бага саад тогтортой учирч байна. Тэдэнд кирилл бичиг хурдан сурахад сайн давуу тал бас байна. Үүнд:

1. Адилхан монгол хэлтэй монгол үндэстэн болохоор
2. Монгол улсаас гадна байгаа монголчуудын хувьд Монгол улс бол дэлхийн

бусад улс орны адил тусгаар тогтносон, хэл соёлоо хадгалж яваа, монгол үндэстний цөм улс болохын хувьд



THE CULTURAL WAY

3. Монгол улсын соёл боловсролоос сурч эзэмших чин хүсэлтэйн улмаас

4. Нэгэнт кирилл бичгийн ангийг сонгон орж суралцаж байгаагийн улмаас сайн

кирилл бичигтэн болж, ажлын байртай болох хүсэл эрмэлзлэлээс

5. Монгол улс болон БНХАУ хоёр бүх талын түншдэдийн гэрээ байгуулж, улс

төр, эдийн засаг, гадаад худалдааны гэрээ хэлэлцээр, хамтын ажиллагааны олон талын үйл хэрэг өргөжин дэлгэрч байгаагийн улмаас харилцан тодорхой ойлголцох, нэр томъёог зөв ухаарч тэмдэглэх зэрэг өргөн хэрэглээ шаардагдах болсоноос

Гэхдээ л олон зууны турш монгол бичгээ хэлнийхээ амин сүнс болгон хэрэглэсээр ирсэн тул хурдан хийгээд алдаа мадаггүй сурахад зарим нэг бэрхшээл тохиолдсоор байна. Үүнд дараах хэдэн зүйл ажиглагдаж байна.

1. Монгол бичиг, кирилл бичиг хоёрын бичлэгийн зөрүүгээс.

Энэ нь монгол

бичиг дээрээс доош уналтын зарчмаар ихэнх үсгийг товчлон, хүний амнаас гарсан болгоныг маш хурдан бичиж болдог бол кирилл бичиг зүүнээс баруунш хэвтээ байдлаар товчлон бичилгүй хурдцын хувьд удаан бичдэгээс шалтгаалж байна. Төгсөх ангийн оюутнууд ч гэсэн юм бол монгол бичгээрээ бичихийг илүүд үзэх нь бий. Нэгэнт дадаж хэвшсэн, гарт орсон бичгээрээ бичих нь амар байдаг бололтой. 1941 онд Монгол улс кирилл бичигт шилжээд төр засгийн олон байгууллагуудад шинэ бичигт сургах курс, дамжаа байгуулахад монгол бичигтэй ахмад нам, төрийн албан хаагчид юм бол монгол бичгээрээ бичих нь нэн элбэг байдаг байсан нь дээрхтэй агаар нэгэн буй.

2. Монгол бичиг, кирилл бичгийн зөв бичих дүрмийн зөрөөтэй байдлаас. Энэ

нь монгол бичигт урт эгшигийн систем байхгүй хийгээд орчин цагийн монгол хэлэнд урт эгшигийг давхар эгшгээр тэмдэглэдэг шалтгаанаас болж баатар хэмээн бичих үгийг *bagatur* хэмээн монгол бичгээр бичдэгийн улмаас батар юм уу багатар хэмээн бичих нь нь олонтоо. Кирилл бичиг үсэг бичлэг болоод хэлзүйн үзэгдлийг тэмдэглэх будлиан дагуулсан 124 дүрмээс бүтдэг бол монгол бичиг олон зууны турш сонгодог монгол бичиг болтлоо хөгжин, шалгаралаар зохицон гарч, хэвшиж тогтсон 60 орчим дүрэмтэй. Үүнээс болоод кирилл бичгийг сайн суртлаа зөв бичгийн дүрмийн алдаа маш их хийдэг. Нэрт монгол судлаач өвөрмонгол эрдэмтэд алдаатай бичих бөгөөд 20 жил Монгол улсад ажиллаж, амьдарсан өвөрмонгол эрдэмтэн ч алдаатай бичих нь



THE CULTURAL WAY

бий. Манай Монгол улсын олон нийтийн мэдээллийн хэрэгсэлүүд, төрийн байгууллагуудын албан хаагчид зөв бичих дүрмээ хайхрахгүй алдаатай бичиж байгаа болохоор тэд ч бас аргагүй юмуу даа. Монгол улсын хэлний хууль гараад 2 жил болж байгаа боловч нэгэн мөр болохгүй дур дураараа бичих явдал үргэлжилсээр л байна.

3. Баримжаа авианы ялгаанаас. Монгол улсад халх аялгууг утга зохиолын

хэлний баримжаа авиа болгосон бол ӨМӨЗО-нд цахар аялгууг баримжаа авиа болгодог. Халх аялгуунд ч, ц, ж, з хэмээх дөрвөн гийгүүлэгч авиа буй бол цахар аялгуунд ч болон ж байхын улмаас *цас* хэмээх бичихийг *час*, *сайн байцгаана* уу хэмээхийг *сайн байчгаана* уу хэмээн бичих нь түгээмэл. Ярихдаа ч ингэж ярьдаг билээ.

4. Нутгийн аялгууны зөрөөнөөс. Монгол улсад халх, ойрод, буриад хэмээн 3

том аялгуу, олон дэд аман аялгуу байдаг хэдий ч утга зохиолын хэлэндээ уусан хэвшиж, нутгийн аялгууны үгс нь нэгэнт үгсийн сандаа шингэн хэвшсэн байдаг. Харин өвөрмонголын нутгийн аялгуу нь цахар, ордос, харчин хорчин баарин хэмээх 3 том аялгууд голлон хуваагдах хэдий ч ихээхэн нөлөөтэй жирим мэтийн олон салбар аман аялгуу байх хийгээд монгол бичиг аль ч нутгийн аялгуунд зохицож дундын гүүр болж байдгийн улмаас нутгийн аялгуугаараа бичих тохиолдол элбэг байна. Кирилл бичгээр *болохгүй байна* хэмээхийг тунлио буюу жирим аялгуугаар *болхулаа* хэмээн бичих нь бий. Монгол бичигт эгшиг гийгүүлэгч сөөлжин орох зарчимтайн улмаас “*болно*” хэмээн кириллээр бичдэг үгийг “*болно*” хэмээн бичих нь түгээмэл.

5. Кирилл бичигт тийн ялгалын нөхцөлийг залгаж бичдэг бол монгол бичигт

саланги бичдэг хийгээд монгол бичигт цөөн тооны тогтсон нөхцөл байдаг бол кирилл бичигт эр, эм, эрс хүйсийг дагуулах мөртөө бас зөрчдөг олон тооны тийн ялгалын нөхцөлтой байдгийн улмаас голдуу эм хүйсийн нөхцөл залгах нь элбэг байдаг. Манай монголчууд ч гэсэн энэ алдааг хийж байх нь телевизийн зар сурталчилгаа болон хувь хүмүүсийн бичиг хэрэгт харагдаж байдаг. 2005 оны үед академич Д.Төмөртоогоо нарын боловсруулсан кирилл бичгийн дүрмийн шинэ төсөл энэ саад бэрхшээлийг арилгаж маш цэгцтэй болсон боловч нийгэм хүлээж аваагүйн улмаас хэрэгжээгүй билээ. Тэр цагт энэ төслийг Монгол улсад сурч байсан өвөрмонголчуудад танилцуулахад ийм байвал бидэнд кирилл сурахад ихээхэн амар байх юм байна хэмээн сайшааж байсан билээ. Монгол бичигт үг нөхцөл хоёрыг тодорхой ялгаж саланги бичдэг бол кирилл бичигт хамт бичдэгийн улмаас нөхцөлийг саланги бичих явдал нилээд буй.



THE CULTURAL WAY

6. Я-гийн төрлийн үсгийн дүрэмийг хэдий сайн тайлбарлавч өвөрмонголчуудад маш ойлгомжгүй байдаг. Ямаа хэмээх үгийг монгол бичигт *itaga*: хэмээн байх тул има юмуу имаа хэмээн бичих нь элбэг.

7. Нэр томъёо, үгсийн сангийн зөрөө нилээд бий болж байна. Энэ нь бичвэр

уншиж ойлгоход саад болдог учраас заавал тайлбарлан ойлгуулах, орчуулж хэлэх шаардлага гардаг. Ялангуяа хил, гааль, гадаад худалдаа, орчин үеийн техник технологийн нэр томъёо хятадаас орчуулан авсан байх хийгээд энгийн зарим хэллэг ч орчуулгаар дамжсан байх нь бий. Гүйцэж түрүүлэх гэхийг *тэрэг давах* гэх мэтээр.

Кадар-боловсон хүчин

Нэр мэдүүлэх-бүртгүүлэх

Албан гэр- оффис, албан газар

Зарах-хэрэглэх, ашиглах

Зэрвэсхэн бороо- түр зуурын бороо

3 дэсийн салхи- 3 метр секунд салхи

Тунгалагшина-цэлмэг байна

Тунгалаг- цэлмэг

Зах дэлгүүр-зах зээл

Цагаан ногоо- байцаа

Шалган байцаах-шалгах

Түм- мянга

Дөхөм болох-амар болох

Цахилгаан цэнэг-цахилгаанаар ажиллах

Нийтийн унаа-автобус

Өөртөө засах орон-автономит эрхтэй орон

Динхуа-ярьдаг утас

Динхуа даанаа-утасдах

Динхуадах-утасдах

Амтат идээний соёлын найр-жимс болоод цагаан идээний үзэсгэлэн

Амрыг хамгаалах- аюулыг хамгаалах

Интернет сүлжээний худалдаа- интенетийн худалдаа

Өвчин зовлонтой-өвчтэй

Цахилгаан шат түгжрэл үүсэх-цахилгаан шат гацах

Их хэвчээний-их хэмжээний

Үрэгдсэн баатарчууд-амь эрсдсэн баатрууд, нас барсан баатрууд

Ардын баатарчууд-ардын баатрууд

Аюулгүй үйлдвэрлэлийн ажиллагаа- аюулгүй ажиллах

Гүн далайд-далайн гүнд

Георгийн холбоо-гүрж

Дүрс шингээлт-бичлэг, видео бичлэг



THE CULTURAL WAY

Гарагийн дуу-долоо хоногийн дуу
Алтан медаль тоссон-алтан медаль авсан, хүртсэн
Олон улсын анхаарлыг олох- олон улсын анхаарал татах
Машин тэрэг- машин
Охин хүн-эмэгтэй хүн
Тусгай боловсрол- тусгай мэргэжил
Ил тод байцаалт хийх- ил тод шалгалт хийх
Намын шүүжий- намын дарга
Гадаадад оруулалт гаргалт- экспорт хийх
Зах дэлгүүрийн аж ахуй- зах зээлийн нийгэм
Нарийлаг ажил-нарийн ажил
Сонин мэдээний дамжуулах нэвтрүүлэг- мэдээ нэвтрүүлэх
Нийгмийн бэл- улсын мөнгө
Ардын урлагт бахтай- ардын урлагт дуртай
Хуралд зааж гаргаснаар-хурлын тогтоолд зааснаар
Тэтгэмжийн мөнгө гардах-тэтгэмжийн мөнгө авах
Бичиг үзүүлэх-ном сургах
Ухаагуулах хэлтэс-ухуулах хэлтэс
Ардын дууг шингээх-ардын дууг магнитфонд бичиж авах
Дэлгэн борлуулалт- үзэсгэлэн худалдаа
Газар шинжилгээний алба-палентлогийн судалгааны алба
Хулгайлж сонсох-сэм сонсох
Хавсруулах учир байна уу?-танд юугаар туслах вэ?
Оvloх хэрэггүй-хуурах хэрэггүй
Зоогдох-уулзах, ярилцах
Халуун тогооны газрыг ноцоох-халуун тогооны газрыг галлах
Японд өчиж өнгөрсөн-японд очиж үзсэн
Чалчина уу чи-дэмий ярина уу чи
Хатан минь-эхнэр минь
Охин биеэ зүгээр хүнд өгөх-охин биеэ эзэмдүүлэх
Пял-таваг
Түрээсний машин-такси
Шингээлтийн машин-магнитфон
Нанчий халахгүй-пар халахгүй
Охорхон хугацаанд- богино хугацаанд
Күнс байгуулах-компани байгуулах
Баярлан угтана-баяртай хүлээн авна
Урвуулга хийх-хуйвалдаан хийх
Самуурлыг арилгах-будлианыг арилгах
Олноороо-бүгдээрээ
Баярын чимээ-сайхан мэдээ
Дээр дуугаар хэлэх- чанга ярих



Дөгөм байлгах- амар байлгах
Бийр-үзэг
Арвин ярихгүй-их ярихгүй
Мотор-мотоцикль
Төрөгдөл-бодол
Гэртээ номхон суу-гэртээ тайван суу
Дулааны хамгаалалт-хөөсөнцөр хавтан
Хөхүүр-хөөрөг
Хөөрөг-гүүр
Дэвсгэр-гудас
Соргог цэцэг-хүндэтгэлийн цэцэг
Сүрчиг-үнэртэй ус
Судлын зүү-судас тариа
Талагаар- талаар
Хал үзэж амьдарах-бэрхшээл үзэж амьдарах
Тэргэнд гар-машинд суу
Нам жим бол-читээгүй бол
Бүх улсын хэвчээнд-бүх улсын хэмжээнд
Орондоо орох-суудалдаа суух
Ерөөл чинь тогтох болтугай- ерөөл бат оршиг
Би тэрнийг тооно- би түүнд хайртай
Аав суух-аав болох
Битпоны-Битховены
Мизард-Моцарт
Умбал-ач хүү, ач охин
Биеэн байцаалгах- шинжилгээ хийлгэх
Усны үлгэр-усны дээж
Чулуун тос-нефть
Насан баяр-насны ой
Улс гүрний омогшил-улс гүрний бахархал
Хойшдын жам мөр- хойшдын зам мөр
Тос нэмэх газар-шатахуун түгээх газар
Дэмий ханамжгүй-тийм их ханамжтай биш
Асуудлаа тусгах- асуудлаа тавих
Гүн далайгаас авсан чулуун дэгдээхэй- сувд
Алгадах бөмбөг-гар бөмбөг
Сүүдэр- гэрэл зураг
Мөрлөх-дугаарлах, очерлох
Пин пан тоглох-теннис тоглох
Сүрчих ам-цацах ам
Будаа идэх-хоол идэх
Дийлнэ биз-чадна биз



THE CULTURAL WAY

Хавсрахаар ирэх-туслахаар ирэх
Эргүүлэн пайз-эргэлддэг реклам
Эрээлэх хэрэггүй-санаа зовох хэрэггүй
Гарагийн нэгэн-даваа гараг
Гарагийн хоёрон-мягмар гараг
Гарагийн гурван-лхагва гараг
Гарагийн дөрвөн-пүрэв гараг
Гарагийн таван-баасан гараг
Гарагийн зургаан-бямба гараг
Гарагийн долоон-ням гараг
Дивиди таваг-сиди
Дотор гүн суугдах-санаанд тод үлдэх
Бэл оруулах- хөрөнгө оруулах
Учиртай юу-яриатай юу
Наадах-тоглох
Эм юүлэх-эм уух
Өндөр дунд-дунд сургууль
Дээд дунд- ахлах сургууль
Умбалтын уралдаан- усан сэлэлтийн уралдаан
Улаан дэн-улаан гэрэл
Хүчирдэл авчрах-бэрхшээл учрах
Нөхөр-эхнэр
Үйлс босгох-хувиараа ажил эрхлэх
Замдаа хэрсүүл-замдаа болгоомжил
Охор фильм-богино хэмжээний кино
Дөгөмхөн ярих- товч ярих
Үйлс босгох- хувиараа ажил эрхлэх
Озоороосоо-язгуураасаа (урад болон шинэ баргад озоор хэмээн ярьдаг
нь язгуур гэсэн утгатай байна.)
Олон улсын холбоот байгууллага-НҮБ
Тэрэг давах-гүйцэж түрүүлэх
Ураг унагах-үр зулбах
Ураг булаах-үр хөндүүлэх
Асар-өндөр байшин
Хүүхэд авах-хүүхэдтэй болох
Гороо тат-дураа тат
Бие цэвэрлэнэ- бие засах
Цус цагаарах өвчин- цусны өвчин
Хувинчир-амиа бодсон
Хорсох- үзэн ядах
Гээгний хавчуур-үсний хавчуур
Санаа амар бай- бүү зов



THE CULTURAL WAY

Талагаар амьдрах-дэмий амьдрах, ашиггүй амьдрах
Ижилсэж дийлэх-зохицох, тохирох
Хүсэн зөгнөх- ерөөх
Төрсөн өдрийг бэлэглэе-төрсөн өдрийн баяр хүргэе
Нэхэмжил-хөө
Дайны олзлогсод одоогоор мөрлө-олзлогсод жагса
Барууншаа тэгшил-баруун тийш зэрэгц
Мэдүүлье- илтгье
Чанга шийтгэнэ- хатуу шийтгэнэ
Амар түвшнийг хамгаалах- амь насыг хамгаалах
Хамгийн бага үрэгдлээр-хамгийн бага хохирлоор
Төв үнэнчээр хэлэх- чин үнэнээр хэлэх
Эв хамт намын кадр-коммунист намын боловсон хүчин
Илбэ гаргах- илбэ үзүүлэх
Овордох-их зан гаргах
Сайн гэтэх- сайн тагнах, заншлах
Хурдан өнхөр-хурдан зайл
Хавсрах-туслах
Үнэ мөнөөр нь тушаах-үнэн мөнөөр нь хэлэх
Та нарын нүд нь чихэн дээрээ гарчихаж- та нар үнэнийг мэдэхгүй байна
Нүүрийн арьс чинь яагаад ийм зузаан юм-Нүүрээ яагаад ширэлчихсэн юм
Миний хэрэгт гар дүрэхгүй бай- миний хэрэгт оролцохгүй бай
Хүүхэд өшгилж байна- хүүхэд хөдөлж байна
Гар уран байна-уран гартай байна
Тэрэг хөрвөх-машин онхолдох
Тийрэлтэт сум-пуужин
Биеэн сул тавь-тайвшир
Ном хаялцааны багийн гишүүд- эрдэмийн зөвлөлийн гишүүд
Номын дүү-доод оны оюутан
Хундага мөргүүлье-хундага тулгая
Архины дагуул үг-хундагны үг
Гамбай-ёроолы нь гаргая
Голдлог болгох-ерөнхий агуулга болгох
Нийгмийн байцаалт-анкетийн асуулт
Соёлын хир хэмжээ-боловсролын төвшин
Анх зэргийн дунд сургууль-6-9-р анги
Өндөр зэргийн дунд сургууль- 10-12-р анги
Анх зэргийн бага сургууль-1-6-р анги
Дээд хугацаа-Намраас өвлийн хичээлийн хугацаа
Доод хугацаа-Хавраас зун хүртлэх хугацаа
Сурлага төгсөх ёслол-хонхны баяр



Ураг эрхлэгч-хуримын хөтлөгч

Эр эм болсныг нийтлэнэ- эхнэр нөхөр болсныг зарлана

Миний хэлсэн онолоо биш үү-Миний хэлсэн үнэн биш үү

Би дотроо тоотой-би дотроо бодолтой

Тамирын ордон –биеийн тамирын заал, танхим

Осолдлоо-уучлаарай³

8. Бас бусад шалтгаан хийгээд хүрээлэн байгаа тухайн улсын албан ёсны хятад

хэлний нөлөөлөл ч буй.

Иймийн тул дараах хэдэн дүгнэлт гарч байгаа юм. Үүнд:

1. Эдгээр бэрхшээлт шалтгааныг хэл шинжлэлийн үүднээс судлан гаргаж,

кирилл үсэг суралцагсдын бэрхшээлийг арилгах тайлбартай гарын авлага гаргах шаардлагатай байгаа юм. Энэ нь гаднын монголчуудыг кирилл үсэг сурах дөт зам болохоос гадна Монгол улсын соёл боловсролоос суралцах, биднийгээ ойлгох, нягтрах дөт зам болох талтай.

2. Нэг монгол үндэстэн байтлаа хоёр өөр бичигтэйн улмаас хэлний зүй тогтлын

ихээхэн зөрөө гардаг нь Монгол улсын монголчууд орчин цагийн монгол хэлний хэлзүйн зөв бичих дүрмээ монгол хэлний зүй тогтолд зохицуулан засан сайжруулах хэрэгтэй гэдгийг бас сануулж байгаа юм.

3. Нөгөө талаар Монгол улсаас гадна суугаа дийлэнх олон монголчуудаа бодож

эртнээс авхуулаад одоо болтол хэл, соёлын гүүр болж байгаа монгол бичгээ төрийн бичиг болгож авахыг Монгол улсын монголчуудад сануулж байгаа ч хэрэг юм. Изриаль улс 1000 гаруй жилийн өмнө аль эрт Соломон хааны үед хэрэглэж байсан еврет бичиг болоод хэлээ улсын албан ёсных болгож дэлхий дахины еврейчүүдийг хэл, соёл, боловсролоор нь нэгтгэн ойрх дорнотод баавгайлж байгааг бид бүхэн бэлээхэн мэдэх билээ.

4. Мөн тэрчлэн бид бүхэн өөрсдийгөө Чингисийн монгол хэмээн цээж дэлдэх

мөртөө Чингисийн үр сад болох гадна суугаа монголчуудаа харь улсын, гаднын хүн хүн хэмээн өөчлөн ялангуяа хилийн цаана суугаа өвөрмонголчуудаа хужаа хэмээн гадуурчлах нь зүй бусын хэрэг бөгөөд аль социализмын үеийн гаднын нөлөөтэй хагалан бутаргах үзлийг таягдан хаяж, еврей үндэстний нэгэн адил нийт монгол үндэстний

³ Л.Чулуунбаатарын хувийн цуглуулгаас




THE CULTURAL WAY

хэмжээгээр сэтгэж, омогшиж явбал таарах мэт мунхаглан бодно би. Тэрчлэн Монгол улсын албан ёсны анкет дээр байдаг яс үндэс гэсэн хагалан бутаргах асуултыг үндэстэн гэсэн асуултаар сольж, монгол гэж хариулдаг болгомоор байгаа юм. Бусад улс орных ч тийм л байдаг билээ.

5. Бичиг үсэг хэл соёлтой холбоотой дээрх асуудлуудыг шийдвэрлэвэл

монголчууд тамын тогооноос гарч, монгол үндэстнүүд хэл, соёлоороо ойртон нягтарч Монгол улсын хөгжил цэцэглэлтэд нэгэн мөрний хүчит урсгал болох бусуу. Энэ хурлын сэдэв ч ийм билээ. Бүтэн жил кирилл бичигт суралцсан өвөрмонгол оюутны сэтгэгдлийг жишээ болгон хавсаргав.

 Соёлчүүдэд

Миний багш

Кирилл дээр сурна гэж сэтгэж ядан байсан дийл. Нэн таашаан багшаа харъя гэж манай их бодомт байсан юм.

Анх багшаа харла. Сэтгэлд ясан эелдэг санагдах би. Хархад тэлхэн эхрэнгүй санагдах би. Францй нэгдүгээр тэнхэл гээр багшийн тэлхий ойгохгүй арга дарагдан, яахаа мэтэхгүй гэвч байсан. Сүлээр нь багш ч диг нарот ойгооме, үг тэлэх үедээ амаан эрэнж, дигны сайхан харгалсан байна. Дараагч нь диг харгалзан хавсаргалсан, нэг нэгнэг нэгэнгээ улам ойгоох болв.

Би үүдгээ монгол тэлхийн багшааг бусад тийн сайн багштай үерэхгүй л болсон гэж бодомт байсан. Төвс би амаар бас нэгэн сайн багштай үерсан тийн сүтэй сайхан дийл багшаа би үнэн сэтгэлээс тене: Хэзээ ч мартахагүй! Өргөн гэлээр

нэгдүгийн нь дийэрнэ. ийм багштай үерсандна омогшино!



THE CULTURAL WAY

ABSTRACT

There are approximately 10 million Mongols in the world. The population of Mongolia reached 3 million as of 2015. There are around 5 million Mongols in Inner Mongolia of China; some of them live in Gansu and Xinjiang. Today Cyrillic alphabet is used as an official writing system in Mongolia while Mongol script is still used in Inner Mongolia. Since 1990 there have been efforts to reintroduce the traditional Mongol script as an official letter but this attempt came to nothing. The Mongols, who are living outside Mongolia, want to study Cyrillic. Since 2010 Cyrillic script has been started teaching for the students of some universities in China. The bilateral relations between Mongolia and the People's Republic of China have been expanding on all sides. While teaching Cyrillic at university students, they face some difficulties regarding to orthography of two scripts.

НОМ ЗҮЙ

1. Буянтогтох, Нутгийн аялгууны шинжлэл, ӨМАХХ, 2007
2. Ц.Норжин, Баримжаа авиа-Цахар аман аялгуу, ӨМАХХ, 2001
3. Сэцэн, Монгол хэлний нутгийн аялгууны шинжлэл, ТҮИСХХ, 200
4. Л.Чулуунбаатар, Бичиг үсэг болон орчуулгын тухай өгүүлүүд, УБ., 2015
5. Л.Чулуунбаатар, Нүүдэлчин монголчуудын бичиг үсгийн соёл, УБ., 2011
6. Ц.Шагдарсүрэн, Эх хэлээ эвдэхгүй юмсан, УБ., 2010
7. Энэ бол Өвөр Монголын Өөртөө Засах орон, Таван тивийн нийтлэл хэвлэлийн хороо, 2007
8. https://newmedee.blogspot.com/2015/01/3_21.html
9. https://mn.wikipedia.org/wiki/Өвөр_Монголын...



ЯПОН ХЭЛНИЙ ОЛОН УТГАТ ҮЙЛ ҮГ “上がる” -ИЙН УТГЫН
ӨРГӨЖЛИЙН ТАНИН МЭДЭХҮЙН СУДАЛГАА

Жао Хашэнь Гаова*

ХУРААНГУЙ

Японы “上がる” үйл үг нь “өсөх, дээшлэх, дээшлэх” гэсэн утгатай бөгөөд янз бүрийн утга, хэрэглээтэй нийтлэг нэр томъёо юм. Энэхүү бүтээл нь түүний олон утгын баялаг үзэгдлийг онцолж, танин мэдэхүйн үйл явцыг түүний янз бүрийн утга, тэдгээрийн харилцан уялдаа холбоог судлах замаар шинжлэх болно. Танин мэдэхүйн хэл шинжлэлийн онолын хүрээ нь энэхүү шинжилгээг удирдан чиглүүлдэг. ‘上がる’ гэх үгийн утга хоорондын уялдаа холбоог тодорхой харж болно. Энэхүү холболтыг прототип, дүрслэлийн схем, метафор, метоними зэрэг танин мэдэхүйн механизмаар тайлбарладаг. “上がる” гэдэг үгийн олон утгыг ойлгох нь япон хэл сурах чадвар, ойлголтыг сайжруулахад тусалдаг. Түлхүүр үгс: *Олон утгат үйл үг, сайжруулалт, танин мэдэхүйн хэл шинжлэл, танин мэдэхүйн үгсийн сан*

* Чи Фөн ДээД Сургуулийн багш, Хэл шинжлэлийн ухааны доктор



关于日语多义动词“上がる”语义扩张的认知研究

赵哈申高娃*

(赤峰学院 内蒙古自治区 赤峰市 024000)

摘要:“上がる”是日语中一个常见的自动词，其基本意义为“上升、登、升起”。然而，在实际应用中，这个词汇具有多种意义和用法，形成了丰富的多义现象。本文以认知语言学为理论指导，通过分析上がる的各个义项及其之间的内在联系，探讨其词义认知过程。研究发现，“上がる”一词的各个义项之间存在明显的关联性，可通过原型、意象图式、隐喻、转喻等认知机制相互衍生。掌握“上がる”的多义性有助于提高日语学习者的语言运用能力和理解水平。

关键词:多义动词；上がる；认知语言学；词义认知

一. 引言

日语作为一种复杂的语言系统，其中蕴含着丰富的语义变化和词汇多义性现象。多义动词作为日语词汇中的重要组成部分，其语义的多样性和灵活性为语言交流提供了广阔的空间。其中，“上がる”作为一个典型的多义动词，其语义在不同语境下展现出多种不同的解释和用法，这种现象引起了语言学界的广泛关注。“上がる”这一动词在日语中具有基本含义，即描述物体从低处向高处的移动或状态的改变。然而，随着语言的不断发展和运用，其语义逐渐扩展至更广泛的领域，涵盖了地位的提升、精神的振奋、情绪的高涨等多种抽象概念。这种语义扩张的过程并非简单的词义衍生，而是涉及到认知机制、语境因素以及语言使用者的心理过程等多个层面的复杂交互。因此，从认知的角度出发，对“上がる”的语义扩张进行研究具有重要的理论意义和实践价值。首先，通过对该动词的语义变化进行深入剖析，我们可


*赵哈申高娃(1981.9)，女，蒙古族，内蒙古扎鲁特旗人，赤峰学院外国语学院讲师，语言学博士，研究方向为契丹文字、日语语言文学。



以更好地理解人类语言的认知结构和信息处理机制。其次，这种研究有助于揭示语言发展和演变的规律，为语言学理论的完善提供实证支持。此外，对于语言教学和翻译实践来说，掌握多义动词的语义扩张规律也有助于提高语言运用的准确性和灵活性。

一、“上がる”基本意义及意象图式

“上がる”基本意义为人/动物（整个身体）按照自己的意愿移动（从一个地方到另一个地方）到更高的地方。人/动物（整个身体）通过倾斜路径向高处移动。这个动词所引发的意象图式在人们的认知中构建了一个基本的空间方向感，即向上。这种空间方向感是理解“上がる”语义扩张的基础。



例如：

- (1) 山手線のホームに上がる。（登上山手线站台。）¹
- (2) 老人はゆっくりと階段を上がっていった。（老人漫漫地上楼梯。）

语义（1）（2）表示“上がる”的基本意义，语义（1）表示向上移动，语义（2）表示人的整个身体通过倾斜路径向高处移动。

二、语义扩张的路径与认知机制

多义现象是语言中的一种普遍现象，它反映了人类认知的复杂性和灵活性。在日语中，“上がる”作为一个多义动词，其意义的扩展是通过认知机制中的隐喻、转喻等方式实现的。隐喻是基于事物之间的相似性进行的意义映射，而转喻则是基于事物之间的相关性进行的意义转换。这些认知机制使得“上がる”的意义能够从一个领域扩展到另一个领域，从而形成了丰富的多义网络。

（一）物理领域的扩张：

从“上升、起来”的基本含义出发，“上がる”首先扩展到物理领域的其他相关概念。例如，它可以用来描述物体的升起、移动、站立或者价格的上涨等。这些扩张都围绕着“向上”这一核心意象进行，是对基本含义的直接延伸。

例如：

¹ 本文例句出处为 <https://verbhandbook.ninjal.ac.jp/headwords/agaru/>。基本動詞ハンドブック。



- (3) メインホールに国旗があがった。(国旗升上主杆了。)
- (4) 川の水位が上がった。(河水上涨了。)
- (5) どうぞおあがりください。(请上来。)
- (6) 石油の値段があがっている。(石油价格在上涨。)

语义(3)表示物体整体移动到更高的位置(如空中)(从而更容易被看到)。语义(4)表示人(整个身体)从水下移动到没有水的地方。语义(5)表示人们从房子外面走到房子里面。语义(6)表示与某个参考点(时间点)相比,(所感知到的)数量增加了。以上例句表示“上がる”的中心意义的延伸含义。

(二) 抽象领域的扩张:

随着语言的发展和使用,“上がる”的语义进一步扩展到抽象领域。它可以表示地位的提升、精神的振奋、情绪的高涨等。这种扩张是基于人们对“上升”这一动作的隐喻理解,将物理空间的变化映射到社会、心理等抽象领域。

例如:

- (7) 知事の政策に、県民から抗議の声があがった。(知事政策遭到了该县人民的抗议。)
- (8) いつのまにか、成績があがった。(不知不觉中成绩上来了。)
- (9) 娘が中学校にあがった。(我的女儿开始上中学了。)
- (10) 田中さんがあがっているのがわかった。(能感觉到田中在紧张。)

语义(7)表示相当多的人对吸引他们的事物产生意见。语义(8)表示水平/标准更高。语义(9)表示新加入(更高的)教育机构。语义(10)表示人们将自己置于非常环境中,无法保持冷静。根据以上例句发现“上がる”这一词的意义从基本意义延伸到了物理领域的相关意义,再隐喻到精神层面、社会地位、心理活动等更深层次的扩张意义。

三、意象图式的转变与强调焦点

在语义扩张的过程中,意象图式的转变和强调焦点也起到了重要作用。例如,当“上がる”用于描述地位提升时,人们更关注的是结果状态,即达到更高的位置;而当用于描述情绪的高涨时,人们则更关注过程的连续性,即情绪从低落到高涨的变化过程。



(11) 大捜査によって、ようやく犯人があがった。(经过大搜捕，终于找到了罪犯。)

(12) 彼は仕事が上がると、電車にのって球場に向かった。(下班后，他乘火车去了体育场。)

(13) 旅費が思ったより安くあがった。(旅费比预期的要便宜。)

(14) ようやく雨があがった。(雨终于停了。)

(15) 環境問題や温暖化の問題が話題としてあがった。(环境问题和全球变暖成为讨论的话题。)

(16) 田中さんは、今回の企画が成功し、一段と評価があがった。

(该项目的成功进一步提高了田中先生的声誉。)

语义(11)表示找到了要找的人/物。语义(12)表示工作或其他活动完成(在工作一段时间后)。语义(13)表示费用控制在一定范围内。语义(14)表示完成、終了，雨停。语义(15)表示将人和物置于吸引注意力的环境或条件中。语义(16)表示地位、评价的提高。根据以上句子发现“上がる”的扩展意义深入到人们关注结果状态、情绪高涨、地位的提高等领域。

四、多义性的形成与认知处理

“上がる”的多义性是通过语境的特定化和语言的规约化形成的。在不同的语境中，“上がる”与不同的名词、副词等搭配使用，形成了丰富的语义表达。同时，人们在理解和使用这个词时，会根据具体的语境和背景知识，进行认知处理，选择合适的语义解释。

(17) 惯用句：

株が上がる。表示“更高的声誉/知名度”之意。

例如：今度のプロジェクトでの活躍で、彼の社内での株があがった。(他在即将到来的项目上的工作提高了他在公司内部中的地位。)

頭があがらない：表示“觉得亏欠对方，将自己置于从属地位”之义。

例如：私のミスをたびたび救ってくれた部長には、頭があがらない。(我不能把我的头归功于我的经理，他经常把我从错误中解救出来。)

(18) 复合动词：与其他动词结合构成新的动词，丰富了语义含义。

例如：あがり切る(进入)、あがりこむ(走进)、舞いあがる



(飞翔)、立ちあがる(起立)、飛びあがる(跳起来)、盛りあがる(涌上来)等很多。

(18) 复合名词:

例如: 立ちあがり(站立)、出来あがり(做成)、跳ねあがり(跳起)、成りあがり(暴富)、繰りあがり(提前)、盛りあがり(涌上)、つま先あがり(漫坡路) 起き上がりこぼし(不倒翁)等。

四、结论

本文通过对日语多义动词“上がる”意义扩展的认知研究,我们可以发现其意义扩展的机制和规律。隐喻和转喻等认知机制在词义扩展中发挥着重要作用,使得“上がる”能够从一个领域扩展到另一个领域,形成了丰富的多义网络。同时,认知因素和语境也对词义的理解和解释产生着重要影响。因此,我们需要运用认知语言学的理论和方法,深入探究日语词汇的多义现象和语义复杂性,以更好地理解 and 运用日语。

今后的研究可以进一步探讨“上がる”与其他相关词汇的关联和差异,以及在不同语境下的具体用法和表达效果。此外,还可以结合语料库等实证研究方法,对“上がる”在实际语言使用中的多义现象进行定量分析和描述。这些研究将有助于我们更深入地理解日语词汇的语义特点和变化规律,为日语教学和翻译实践提供有益的参考和借鉴。

参考文献:

- [1] 侯占彩.《日语词汇与词汇教学研究:语言·文化·认知·对比》[M].九州出版社,2022(5).
- [2] 刘钦.关于日语多义动词“切る”语义扩张的认知研究[J].《外语教研》,2019(9),67-68.
- [3] [美]威廉·克罗夫特、[英]D.艾伦·克鲁斯.《认知语言学》[M].商务印书馆,2022(5).
- [4] 项往.关于日语多义动词“飛ぶ”语义扩张的认知研究[J].《科教论坛》,2018(7),40、60.



[5] 张晓涛. 《基于认知规律的汉字教学研究》[M]. 汉字文化, 2008 (6).

[6] <https://verbhandbook.ninjal.ac.jp/headwords/agaru/>. 基本

動詞ハンドブック。

ABSTRACT

The Japanese verb ‘上がる’, meaning "to rise, to ascend, to rise," is a common term with various meanings and uses. This paper focuses on the rich phenomenon of its multiple meanings, analyzing the cognitive process through an examination of its various meanings and their interconnections. The theoretical framework of cognitive linguistics guides this analysis. The interconnection between the meanings of the word ‘上がる’ can be clearly observed. This connection is explained by cognitive mechanisms like prototype, imagery schema, metaphor, and metonymy. Understanding the multiple meanings of ‘上がる’ can help Japanese learners enhance their language skills and comprehension.

Keywords: *polysemous verbs; upgaru; cognitive linguistics; lexical cognition*

МОНГОЛ ХЭЛНИЙ ҮГСИЙГ ХЭРХЭН АЙМАГЛАХ БА УХАГДАХУУНЧЛАХ
ТУХАЙ ХАРЬЦУУЛАН ШИНЖЛЭХ НЬ

Залгаахүү*

ХУРААНГУЙ

Тус өгүүлэлд улсын дотоод гадаадын “орчин, одоо цагийн монгол хэл”-ний төлөөлөх чанартай хоёр ном бүтээлийг сонгон, үгсийг аймаглах зарчим, үгсийн аймгийн ухагдахуун гэх хэдэн талаас харьцуулан судалж, үгсийн аймгийн судалгаанд лавлалт болгохыг зорьсон юм.

Түлхүүр үгс: *Үгсийг аймаглах зарчим, үгсийн аймгийн ангилал, ухагдахуун*

Үгсийн аймгийн тухай судлал бол хэл зүйн судлалын нэгэн чухал аймаг болох бөгөөд тухайн судалгааны ажил нь маш эртнээс эхэлсэн юм. Адил бус цаг үе, адил бус улсын монгол судлаач үгсийн аймгийн тухай адил бус үзэлтэй байдаг. Ш.Лувсанданзаны “Орчин цагийн монгол хэл” ба Түмэнжаргалын “Одоо үеийн монгол хэл”-ийг дөхөм харьцуулан, хоёр бүтээлийн үгсийг аймаглах зарчим, үгсийн аймгийн ангилал, үгсийн аймгийн ухагдахууныг хураангуйлахаар дамжин монгол хэлний урт хугацааны үгсийн аймаглах асуудалд шинэ үзэл танилтыг олгоно. Тодорхойлолт: Бүтээлийг нэрийг товчилжээ. Ш.Лувсанданзаны найруулсан “Орчин цагийн монгол хэл”, ӨМАХХ., 1982.12 3-р хэвийг товчлоод “Орчин” ба ① гэнэ. Түмэнжаргалын найруулсан “Одоо үеийн монгол хэл”, ӨМИСХХ., 2018.8 1-р хэвийг товчлоод “Одоо” ба ② гэнэ.

Нэг. Үгсийг аймаглах зарчим

Аливаа нэгэн хэлний үгсийг ангилан аймаглах тухай асуудлыг тод болгохын тулд юуны өмнө үгсийг ямар ямар зарчмаар ангилж болохыг тодруулах хэрэгтэй. Хэлний үгсийг аймаглах баримжаа болгодог зарчмыг

* Өвөр Монгол Их Сургуулийн Монгол Судлалын Дээд Сургуулийн магистрант



үгсийг аймаглах зарчим гэнэ. Үгсийг аймаглах зарчмын тухай харьцуулж үзвэл дараах мэт.

“Орчин”: Үгсийг аймаглахад хэл зүй, хийсвэр утгынх нь шинжээр үндэс баримжаа болгодог. Хэл зүйн шинжийг дотор нь үг зүйн шинж, өгүүлбэр зүйн шинж гэж ялгаж болно. Өөрөөр хэлбэл үг зүйн шинж, өгүүлбэр зүйн шинж, үгийн хийсвэр утгын шинжээр үндсэн зарчим болгох болно. Үг бүрт ногдсон тодорхой утга гэж байдаг. Үгсийн тус тусын тодорхой утгатай, нэг үгийн тодорхой утгатай, нэг үгийн тодорхой утгыг нөгөө үгэнд тулган ногдуулж болохгүй. Үгсийн ерөнхий, хийсвэр утга нь үг тус бүрийн бодит утгаас ялгаатай, хэлэлцэгч этгээдэд шууд анхаарагдахгүй боловч уг үгсийн тодорхой бодит утгаар дамжиж илэрнэ.

Үг зүйн шинж нь хэл зүйн утгыг илтгэх янз бүрийн дагавар, өөрөөр хэлбэл үг хувилгах олон зүйлийн дагавар, жич нэг үгнээс өөр шинэ үг үүсгэх янз бүрийн үг бүтээх дагаварын зүйлээр илэрнэ. Жишээлбэл, монгол хэлний нэр үгсийн үндсэн шинж нь олон тоо, тийн ялгалаар хувилах, хамаатуулахын дагавар авахаар илэрнэ. Энэ мэтээр монгол хэлний үгсийг аймаглахад үг зүйн шинж нь үлэмж тодорхой баримжаа болно.

Өгүүлбэр зүйн шинж нь үг бүр өгүүлбэрт хэрэглэгдэхдээ цөм адилгүй, зарим үг гол төлөв өгүүлэгдэхүүн тусагдахуун болж зарим үг өгүүлэхүүн, зарим үг тодотгол болох буюу зарим үг өгүүлбэрийн биеэ даасан гишүүн болдоггүй, жич янз бүрийн үг холбож утга илрүүлэхэд зарим үг нөгөө үгтэйгээ холбогдож илэрнэ. Өгүүлбэрийн зүйн шинж нь үгсийг аймаглахад анхаарвал зохих зүйлийн нэг бөгөөд заримдаа чухал баримжаа болно.

“Одоо”: Үгсийн аймаг гэдэг нь үгсийн утга зүй, үг зүйн хувирал ба өгүүлбэрт гүйцэтгэх үүрэг үйлдлийн талаарх ямар нэгэн хэмжээгээр ерөнхийлөгдсөн онцлог бүхий үгсийн бүлгийг хэлнэ. Ангилж хэлбэл үгсийн утгын тал, үг зүйн шинжээр өгүүлбэрт гүйцэтгэх үүрэг үйлдэл зэрэг гурван талаас аймаглана. Утга зүйн зарчим нь хэлэн дэх үгсийг утгын ерөнхий шинжээр нь аймаглах зарчим болно. Жишээлбэл, “уул, ус, халуун, зургаа, дээр, хойно, би, алцаг алцаг” зэрэг үгс нь үгийн сангийн бодит утгатай бөгөөд утга нь өсөд ондоо байдгаар тус тус ялгарна.



THE CULTURAL WAY

Үг зүйн зарчим нь хэлэн дэх үгсийг үг зүйн хувилалынх нь ерөнхий шинжээр нь аймаглах зарчмыг хэлнэ. Жишээлбэл зарим үгс нь тоо, тийн ялгал, хамаатуулах зэрэг үг зүйн хувилалтай байхад, нөгөө бүлэг үгс нь хэв, байдал, төлөв, цаг, бие, тэмдэг үйл, нөхцөл үйл зэрэг үг зүйн хувилалтай байдаг. Өгүүлбэр зүйн зарчим нь хэлэн дэх үгсийг өгүүлбэрт гүйцэтгэх үүрэг үйлдлийнх нь ерөнхий шинжээр нь аймаглах зарчим болно.

Иймээс аливаа нэг хэлний үгсийг аймаглахад үг зүйн, өгүүлбэр зүй, үгийн хийсвэр шинж нь харилцан адилгүй баримжаа болж болно. Жишээлбэл, үг зүйн утга, хэлбэр их баялаг хэлэнд үгсийг нь аймаглахад үг зүйн шинж голлож, тийм биш хэлэнд нөгөө хоёр шинж нь чухал байж болно. Гэвч хэлний үгсийг ангилахад дан ганц үг зүйнх нь шинжээр буюу өгүүлбэр зүйн шинжээр ангилж үл болох нь мэдээж хэрэг. Үүгээр үл барм нэг хэлний үгсийг аймаглахад ч энэ гурван шинж тэмдэг нь үгийн аймаг бүрт харилцан адилгүй хэрэглэгдэж болно. Жишээлбэл, монгол хэлний үгсийг аймаглахад нэр үг, үйл үгийн аймгийг ерөнхийдөө бараг дан ганц үг зүйнх нь шинжээр ялгаж болно. Гэтэл бодит нэр, тэмдэг нэр хоёрыг ялгахад үг зүйнх нь шинжээс гадна өгүүлбэр зүйнх нь шинж, хийсвэр утгыг нь харгалзах хэрэгтэй.

Хоёр адил бус үгсийг аймаглах зарчмаас болж, адил бусын үгсийн аймгийн ангилал бий болжээ. Орчин-д үзэхээр бодит үг, тэмдгийн нэр, тооны нэр, төлөөний нэр, үйл үг, дайвар үг, дагавар үг, сул үг, холбоос, аялга үг зэрэг арван аймаг байдаг. Эдгээр арван аймгийн үгсийг дотор нь бас голлох үгс, туслах үгс гэж хоёр бүлэгт хувааж болно. Үүнд үгийн тусгай утга, хэл зүйн утгатай бөгөөд өгүүлбэрийн аль нэгэн гишүүн болж чаддаг үгсийг голлох үгс гэнэ. Монгол хэлний ийм голлох үгс нь: бодит нэр, тэмдгийн нэр, тооны нэр, төлөөний үг, үйл үг, дайвар үг болно. Ерөнхийдөө дан ганц хэл зүйн утгатай бөгөөд өгүүлбэрийн дотор үгсийн хоорондын харьцааг заах буюу эсвэл нөгөө үгэнд нэмэлт утга оруулах үгсийг туслах үгс гэнэ. Монгол хэлний ийм туслах үгс нь дагавар үг, сул үг, холбоос болно.

Одоо-д үзэхээр бодит үг, хийсвэр үг, аялга үг гэж гурван их үндсэн аймагт ангилж болно. Бодит үг гэдэг нь үгийн сангийн утгатай, үг зүйн төгс хувилалтай бөгөөд өгүүлбэрт биеэ даасан гишүүн болж чадах үгсийг хэлнэ. Монгол хэлний бодит үгэнд нэр үг ба үйл үг багтана. Нэр үгэнд



THE CULTURAL WAY

жинхэнэ нэр, тэмдэг нэр, тооны нэр, төлөөний нэр, цаг орны нэр багтдаг. Монгол хэлний үйл үг, холбох үйл үг, төлөөний үйл үг, нэр үгийн хэлбэрт үйл үг зэрэг багтана. Монгол хэлний хийсвэр үгэнд дайвар үг, дагавар үг, сул үг, холбох үг зэрэг багтана.

Хоёр. Үгсийн аймгийн ухагдахуун

Үгсийн аймгийг хэрхэн аймаглах, ухагдахуунчлахад эрдэмэт адил бус үзэлтэй байдаг. Доор хоёр бүтээлийн үгсийн аймгийн ухагдахууныг харьцуулан шинжлэе.

Бодит нэр/бодит үг: ① Бодит нэр нь юм, үзэгдлийг бодитой, хийсвэр гэж ялгахгүйгээр юм болгон ухааж нэрлэх нэг аймаг үгсийг хэлнэ. Хүний зүйлд хэн?, бусад амьтай, амьгүй зүйлд юу? гэж асуухад хариулах үгс байдаг. Үүнд ерийн нэр, тусгай нэр гэж хоёр хуваан, ерийн нэрийн зүйлд тодорхой нэр, хийсвэр нэр багтана. ② Бодит үг гэдэг нь үгийн сангийн утгатай, үг зүйн төгс хувилалтай бөгөөд өгүүлбэрт биеэ даасан гишүүн болж чадах үгсийг хэлнэ. Монгол хэлний бодит үгэнд нэр үг ба үйл үг багтана.

Тэмдгийн нэр/тэмдэг нэр: ① тэмдгийн нэр нь хүн юм, үзэгдлийн бэлгэ тэмдэг хийгээд үйлийн байдлыг заах бүлэг үгсийг хэлнэ. Тэмдгийн нэр нь ямар?, яаж? гэж асуухад хариулах үгс байдаг. Утгын талаас авч үзвэл “хөх, улаан, цагаан” гэх мэт өнгийн нэрс, “сайн, муу, хуучин” гэх мэт чанарын нэрс, “их, өндөр, нам” гэх мэт хэмжээ байдлын нэрс, “товгор, гурвалжин, дөрвөлжин” гэх мэт овор байдлын нэрс зэрэг байдаг. Монгол хэлний тэмдгийн нэрийг үндсэн тэмдгийн нэр, үүсмэл тэмдгийн нэр гэж хувааж болно. Ямар ч тусгай дагаваргүй “сайн, муу” гэх мэтийн үгсийг үндсэн тэмдэг нэр гэнэ. Үг зүйн аргаар янз бүрийн дагавар залгах буюу хоёр өөр үг, хоршин холбож бүтээсэн тэмдгийн нэрийг үүсмэл тэмдгийн нэр гэнэ. ② тэмдэг нэр нь хүн амьтан, хэрэг бодис, юмс үзэгдлийн шинж чанар, онцлог, бэлгэ тэмдэг, өнгө зүс, дүр байдал буюу үйл байдлын онцлог шинж, эсвэл хэргийн юмны хоорондох харьцааны онцлогийг заан илтгэсэн үгсийг хэлнэ. Ямар?, яаж? гэсэн асуултанд хариулагдана. Монгол хэлний тэмдэг нэрийг түүний утгынх нь хийсвэр шинж ба хэл зүйн онцлогийг нь үндэслэн чанар тэмдэг нэр ба харьцаа тэмдэг нэр гэж хуваана.



THE CULTURAL WAY

Тооны нэр: ① тооны нэр гэдэг нь хүн, юм, үзэгдлийн тоо, дэс дараа, жич үйлийн хэдэн удаа болсон зэргийг заасан үгсийг хэлнэ. Тооны нэр нь хэд?, хэддүгээр?, хэдүүл?, хэд хэд?, хэд орчим?, хэдэн удаа? гэж асуухад хариулах үгс байдаг. Тооны нэрийг дотор нь бас үндсэн тооны нэр, дэс тооны нэр, хам тооны нэр, түгээмэл буюу тойм тооны нэр, дахих тооны нэр, хязгаарласан тооны нэр зэрэг багтана. Үндсэн тооны үгэнд янз бүрийн дагавар залгаж янз бүрийн тооны нэр үүсгэнэ. ② тооны нэр нь хүн амьтан, хэрэг бодис, юмс үзэгдэл ба үйл хөдөлгөөний тоо хэмжээ, дэс дугаар, бүхэл бутархай жич хийсвэр тооны ухагдахууныг заасан нэр үгийг хэлнэ. Хэд?, хэдий?, хичнээн?, хэдүүл?, хэддүгээр?, хэд орчим?, хэдний хэд?, хэд хэдээр? гэх мэтийн асуултанд хариулагдана. Тооны нэрийг түүний хэл зүйн утга хэлбэрийг нь үндэслэн, үндсэн тооны нэр, дэс тооны нэр, хам тооны нэр, тойм тооны нэр, бутархай тооны нэр, түгээмэл тооны нэр гэж хуваана.

Төлөөний үг/төлөөний нэр: ① төлөөний үг бол өгүүлбэрт бодит үг, тэмдгийн нэр, тооны нэр, дайвар үг, үйл үгийг төлөөний хэмээх үгсийг нийтэд нь хэлнэ. Төлөөний үгсийг утгын талаар авч үзвэл бусад аймгийн үгсийн адил ямар юм буюу үйлийг заан нэрлэдэггүй, зөвхөн заан хэлдэг ажээ. Энэ учраас төлөөний үгийн зүйл нь ямар нэгэн ухагдахууныг зааж чаддаггүй. Төлөөний үгийг дотроо биеийн төлөөний үг, заах төлөөний үг, асуух төлөөний үг, тодорхойгүй төлөөний үг, ялгах төлөөний үг, өөрийн төлөөний үг гэж ангилж болно. ② төлөөний нэр бол хүн амьтан хэрэг бодис, юмс үзэгдэл хийгээд үүний бэлгэ тэмдэг, шинж чанар, онцлог, тоо хэмжээ жич үйл байдлын орших болох цагийг төлөөлөн заах, эсвэл ялган заах, хавтгайруулан заах буюу давтан заах үгс болно. Төлөөний нэрийг утгыг нь үндэслэн биеийн төлөөний нэр, зөөх төлөөний нэр, асуух төлөөний нэр, ялгах төлөөний нэр, хураах төлөөний нэр, тодорхойгүй төлөөний нэр, өөрийн төлөөний нэр гэж ангилна.

Үйл үг: ① үйл үг бол цаг, хэв, байдал, төлвийн хэлбэрээр үйл байдлыг заан илрүүлэх үгсийг хэлнэ. Монгол хэлний үйл үгийн олон хэлбэрийг цагийг заах хэлбэр, захирах хүсэх хэлбэр, нөхцөл үйлийн хэлбэр, үйлт нэрийн хэлбэр гэж дөрвөн үндсэн хэлбэрт хуваан үзэж болно. Энэ дөрвөн үндсэн хэлбэр нь ерөнхий хийсвэр утга ба өгүүлбэрт хэрэглэгдэх шинж байдлаараа тус тусдаа өвөрмөц онцлогтой аж. Үүнээс гадна дутмаг үйл гэж монгол бичгийн “а” ба “бү” хоёр мөхсөн язгуураас



THE CULTURAL WAY

үүсгэсэн үйл үгийн нэлээд хэлбэр байдаг. Энэ “а” ба “бү” мөхсөн язгуурт хоёр үйл үг нь үйл үгийн янз бүрийн хувилалаар бүрэн хувилдаггүй тул дурдсан хоёр үйл үгийг дутмаг үйл үг гэнэ. ② үйл үг гэдэг нь үйл хөдөлгөөн, байдал зэргийг явцын хувьд заан илтгэдэг, төлөв, цаг, бие, хэв, байдал зэрэг айн хувилалтай, өгүүлбэрт голдуу биеэ дааж өгүүлэхүүн гишүүн болдог үгсийг хэлнэ. Монгол хэлний үйл үгийг холбох үйл үг, төлөөний үйл үг, нэр үгийн хэлбэрт үйл үг зэрэг багтана.

Дайвар үг: ① дайвар үг бол үйл байдлын болсон буюу болох орон, цаг, мөн яаж болсон буюу болох байдал, хэр хэмжээг заасан бүлэг үгсийг хэлнэ. Дайвар үг нь хаана?, хаагуур?, хааш?, хаанаас?, хэзээ?, хэзээнээс?, яаж? аль хэр гэх мэтийн асуудалд ногдоно. Дайвар үг нь үг зүйнхээ шинж тийн ялгалаар огт үл хувилах буюу заримдаг хувилах үгс байдаг, өгүүлбэрт байц гишүүний үүргийг голлон гүйцэтгэнэ. Дайвар үгийн шинж байдлаар цэвэр дайвар үг, заримдаг дайвар үг гэж хоёр ангилна. Тийн ялгалаар огт үл хувилах дайвар үгсийг цэвэр дайвар үг гэж, тийн ялгалаар хагас ялгалагдах бөгөөд гол төлөв гарахын тийн ялгалаар ялгалагдахыг нь заримдаг дайвар үг гэнэ. ② дайвар үг нь үйл хөдөлгөөний болох хэр хэмжээ, цаг, байдал ба тэмдэг нэрээр илэрсэн шинж чанар, онцлогийн хэр хэмжээг илтгэсэн үгс болно. Дайвар үгийг утгаар нь цагийн дайвар, хэр хэмжээний дайвар, байдлын дайвар гэж хэдэн төрөл зүйлд хувааж болно.

Дагавар үг: ① дагавар үг гэж өгүүлбэрийн доторх нэр үгс ба бусад үгийн хоорондын янз бүрийн харьцааг илэрхийлэх, туслах үгсийг хэлнэ. Дагавар үгийн зүйл нь орон, цаг, нөхцөл шалтгаан буюу зорилго зэргийг заасан, биеэ даасан утгатай байх боловч дангаараа өгүүлбэрийн гишүүн болж чадахгүй. Дагавар үгийн жинхэнэ утга нь ямар нэгэн тийн ялгалаар хэлбэржсэн нэр үгтэй холбогдохдоо сая илэрнэ. Дагавар үгсийг утгаар нь орон, цаг, зорилго, шалтгааныг заах, жич, хамтрах, адилтгах дагавар үг гэж ангилж болно. ② дагавар үг нь дангаараа үгийн сангийн бодит утгагүй, өгүүлбэрт биеэ даасан гишүүн болж чадахгүй, зөвхөн үгсийн хоорондох янз бүрийн харьцааг илтгэдэг, ямагт туслах утгаар хэрэглэгддэг хийсвэр үгийг заана. Дагавар үгийг түүний утгыг нь үндэслэн адилтгах, цаг, орон, шалтгаан, зорилго, тоймлох, хязгаарлах, хураах, тухайлах, давшуурах зэрэг төрөл зүйлд хувааж болно.



THE CULTURAL WAY

Сул үг: ① сул үг нь дангаараа биеэ даасан үгийн сангийн утгагүй, бүхэл өгүүлбэр буюу өгүүлбэрийн доторх ямар нэгэн гишүүнд хэл зүйн янз бүрийн хийсвэр утга нэмж оруулдаг хийсвэр үгийг хэлнэ. Сул үгийг түүний утгыг үндэслэн асуух сул үг, батлах сул үг, хориглох сул үг, үгүйсгэх сул үг, хүч нэмэгдүүлэх сул үг, дахих сул үг, төсөөлөх сул үг, зөвшөөрөх сул үг, тушаах сул үг, дуудах сул үг зэрэг төрөл зүйлд хувааж байна. ② сул үг нь юмс, үзэгдэл, шинж байдлыг тусгайлан заасан утгагүй гол төлөв салангид үгэнд тусгай нэмэлт утга оруулах үгсийг хэлнэ. Сул үг нь нэр, үйл үг шиг янз бүрийн хувилалаар огт хувилахгүй. Биеэ дааж өгүүлбэрийн гишүүн болохгүй. Сул үгээ утгаар нь батлах, асуух, хүч нэмэгдүүлэх, үгүйсгэх, хориглох, эргэлзэх, зөвшөөрөх, тушаах гэж хуваана.

Холбоос/холбох үг: ① холбоос гэж өгүүлбэрийн доторх зэргэцсэн гишүүдийг холбох үүрэг бүхий үгийг хэлнэ. Монгол хэлнээ жинхэнэ холбоос үг “ба” нэгээхэн төдий бий. Холбоос “ба”-аар нэрийн зүйлээр илэрсэн зэргэцсэн хоёр гишүүнийг холбоно. Үүнээс гадна “бөгөөд, хийгээд, болгоод, болоод, болон” гэх мэтийн үйл үгийн урьдчилах, хам нөхцөл болон хоёр, гурав гэх мэтийн тооны нэрийг холбоосын үүргээр хэрэглэх нь арвин бий. ② холбох үг бол үгсийн холбоонд үг, холбоо үг, өгүүлбэрийн бүлэг, өгүүлбэрүүдийг хоор хооронд нь хэл зүйн янз бүрийн харьцаатайгаар холбодог заана. Монгол хэлний холбох үг ба холбоосыг утга үйлдэл нь зэргэцүүлэн холбох үг, сонгон холбох үг, эргэцүүлэн холбох үг, хураан холбох үг, болзон холбох үг гэж хуваана.

Аялгуу үг/аялга үг: ① аялгуу үг нь тусгайлан ямар нэгэн юм буюу үзэгдлийг заан нэрлэхгүй, зөвхөн сэтгэлийн хөдөлгөөнийг илтгэх үгсийг хэлнэ. Аялгуу үгс нь үг зүйн янз бүрийн хувилалаар огт хувилахгүй, мөн өгүүлбэрийн бүтцэд оролцдоггүй. ② аялга үг нь хүн амьтан, хэрэг бодис, юмс үзэгдлийг тусгайлан заан нэрлэсэн биш, зөвхөн хүмүүсийн янз бүрийн сэтгэлийн хөдөлгөөн, сэрэл мэдрэл ба адгуус амьтныг дуудах, яруу найраг, дуу хөгжмийн хөг айзмыг зохицуулахад хэрэглэх үгсийг хэлнэ. Аялга үгийн төрөл зүйл нь гурван зүйлд хуваагдан, нэг н хүмүүсийн сэтгэлийн хөдөлгөөн, сэрэл мэдрэлд холбогдох аялга үг, хоёр нь адгуус амьтныг дуудах, дуудахад холбогдох ялга үг, гурав нь яруу найраг, дуу хөгжмийн айзам хөгийг илтгэдэг. Аялга үг гэдэг нь үгийн



THE CULTURAL WAY

сангийн утгагүй, хэл зүйн утгыг илтгэхгүй, зөвхөн сэтгэлийн хөдөлгөөний буюу адгуус амьтныг дуудах утгыг илтгэх, өөрийн гэх үг зүйн хувилалгүй, өгүүлбэрт биеэ даасан гишүүн болж чадахгүй.

ДҮГНЭЛТ

Хэл шинжлэлд үгсийг аймаглахад чухам ямар зарчмыг баримталж яаж ангилах хэрхэн ухагдахуунчлах тухай асуудал оршсоор байна. Тус өгүүлэлд Ш.Лувсанданзаны “Орчин цагийн монгол хэл”-ний үгсийн аймаглах зарчим нь үг зүйн шинж, өгүүлбэр зүйн шинж, үгийн хийсвэр утгын шинжээр үндэс болгожээ. Тус зарчмаараа арван аймагт хувааж бодит үг, тэмдэг нэр, тооны нэр, төлөөний нэр, үйл үг, дайвар үг, дагавар үг, сул үг, холбоос, аялгуу үг байдаг. Эдгээр арван аймаг үгсийг дотор нь бас голлох үгс, туслах үгс гэж хоёр бүлэгт хуваажээ. Түмэнжаргалын “Одоо үеийн монгол хэл”-д нь үгсийн утгын тал, үг зүйн шинжээр, өгүүлбэрт гүйцэтгэх үүрэг үйлдэл зэрэг гурван талаас аймаглана. Бодит үг, хийсвэр үг, аялга үг гэж гурван их үндсэн аймагт ангилж, бодит үгэнд нэр үг ба үйл үг багтан, хийсвэр үг дайвар үг, дагавар үг, сул үг, холбох үг зэрэг багтана. Дээрхээс гадна, бодит үг ба хийсвэр үгтэй тус тус холбогдох дүрслэх үг, хандлага үг гэдэг хоёр аймаг үг байдаг. Хураангуйлбал, үгсийг аймаглах зарчим үндсэндээ адил, гэтэл нэр томьёоны ухагдахуун, тайлбарлал, хэрэглэлт нь өсөд ондоо болно. Адил ухагдахууныг адил бус үгсээр илтгэнэ. Жишээлбэл холбоос ба холбох үг, аялгуу үг ба аялга үг гэх мэт. Үгсийн аймгийн ангилалд хоёр ба гурван их аймаг хуваасан байж, багтаах хүрээ хэмжээ нь бас адил бус. Зарим завсрын чанартай үгс нь үгсийн ангилалд адил бус үзлийг бий болгожээ.



THE CULTURAL WAY

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Лувсанданзан. Орчин цагийн монгол хэл. ӨМАХХ., 1982
2. Түмэнжаргал. Одоо үеийн монгол хэл. ӨМИСХХ., 2018
3. Тулгуур, Галсан. Орчин үеийн монгол хэл. ЛяоҮнХХ., 2006
4. Монгол судлалын нэвтэрхий толь, үг хэл үсэг бичиг. ӨМАХХ., 2004

ABSTRACT

The study of word families is an important branch of linguistics, and the work of that research began a long time ago. Mongolian scholars of different times and different countries have different views on the province of words. In order to clarify the problem of classifying the words of any language, first of all, it is necessary to clarify the principles by which words can be classified. There is a difference of opinion in how to define and conceptualize the word language. In linguistics, there is still a problem of how to classify and conceptualize words.

Keywords: *predicting words, vocabulary category, concept*

ЛУВСАНДАНЗАНЫ “АЛТАН ТОВЧ” ДАХЬ БУРХНЫ ШАШНЫ НӨЛӨӨ
ТУСГАЛЫГ ШИНЖЛЭХ НЬ

Эрдэнэ*

Лю Чүньши**

ХУРААНГУЙ

13 дугаар зууны үед Хубилай сэцэн хаанаас төвөдийн бурхын шашныг хүлээн авснаас бурхны шашин нь монгол оронд эхлэн дэлгэрсэн юм. Хубилай сэцэн хааны үед бурхны шашин нь улсын шашин болсон ба ялангуяа 16 дугаар зууны үед Түмэдийн Алтан хаанаас монгол оронд бурхны шашныг хоёр дахь удаа дэлгэрүүлснээс монголын түүх бичлэгийн зохиолууд нь төвөдийн бурхны шашны нөлөө тусгалыг хүртэж түүн лүгээ салшгүй барилдлагатай болжээ. Лувсанданзаны “Эртний хаадын язгуур үндэс, энэтхэг төвөдөөс нааш монгол хаад, эн тэргүүн богд Чингис хаан ач нь Хубилай сэцэн хаанаас салсан Даян хаан, түүнээс Лигдэн хутагт хүртэл хураан өгүүлсэн “Алтан товч” хэмээх шастир (товчлоод, Лу. Алтан товч)-аар судлагдахуун болгож, Чингисийн алтан урагтныг бурхны шашинтай холбосон түүх бичлэг жич төр шашин хоёр ёсыг тэгшид явуулахыг чухалчилсан түүх бичлэгийн онцлогийг өгүүлжээ.

Түлхүүр үгс: *Лу.Алтан товч, бурхны шашин, нөлөө тусгал*

17-19 дүгээр зууны үе бол монголчуудын түүх соёлд нэлээд хувьсалт гаргасан цаг үе мөн. Энэ үед төвөдийн бурхны шашин монгол оронд өргөнөөр дэлгэрч, монголчуудын оюун санааг ноёрхож феодалын үзэл ухамсрын хэлбэрийн чухал бүрэлдэхүүн болжээ. 17-19 дүгээр зууны үед бичигдсэн Лувсанданзаны “Эртний хаадын язгуур үндэс, энэтхэг төвөдөөс нааш монголын хаад, эн тэргүүн богд Чингис хаан ач нь Хубилай сэцэн хаанаас салсан Даян хаан, түүнээс Лигдэн хутагт

* 额尔敦尼. Бортохой Дээд Сургуулийн Монгол хэл утга зохиолын салбарын багш, лектор (015000). 15847109273

** 刘春喜. Ганзага 1-р Дээд Зэргийн Дунд Сургуулийн багш (028100). 15248082601



THE CULTURAL WAY

хүртэл хураан өгүүлсэн Алтан товч хэмээх шастир-Лу.Алтан товч, Саган сэцэний “Хаадын үндэсний эрдэнийн товч”-Эрдэнийн товч, Тоба-ийн “Эртний монголын хаадын үндэсний их шар тууж оршив”-Шар тууж, Дхарма гүүшийн “Есөн зүйл бүлэгт Алтан урагтны тод түүх, алтан ястны сэтгэлийн цэнгэл буюу алтан хүртэн мянган хигээст бичиг”-Алтан хүрдэн мянган хигээст”, Рашпунцагийн “Дай Юань улсын болор эрхи”-Болор эрхи зэрэг зохиол бүтээл нь бурхны шашны өнгө будгаар бялхам байж, орчлон ертөнцийн үүсэл бүрэлдэл, хүн төрөлхтний үүсэл гарал жич монголын түүхийг бүр бурхны шашинтай холбож, бурхны шашнаас үүсэлтэй болгож бичсэн байна. Эдгээр түүхэн уран зохиол нь энэтхэгийн хаад, төвөдийн хаадыг монголын хаад лугаа холбож, шагимунийн үүсгэсэн бурхны шашин бол энэтхэгийнхээр үл баран, мөн ч төвөд ба монголын шашин суртахуун мөн гэх дүнг гаргаж, бурхны шашны монголчуудын сэтгэл дэх байр суурийг бататгахаар зорьсон байна.

Нэг. Чингисийн алтан урагтныг бурхны шашинтай холбосон түүх бичлэгийн онцлог

Лу.Алтан товч бол 17 дугаар зууны үед бичигдсэн боловч “Монголын нууц товчоон”-ы нөлөөг гүн хүртсэн түүхэн уран зохиол болно. Яг иймээс Лу.Алтан товчид Монголын нууц товчооны агуулгын ихэнх хэсэг – 282 зүйлээс 233 зүйл нь хуулагдан оржээ. Гэхдээ бас өвөрмөц онцлог бүхий агуулга, үзэл санаа нэмэгдсэн байна. 13 дугаар зууны үед бөө мөргөл бол монголын нийгмийн хөрсөнд соёолон дэлгэрсэн уугал шашин байжээ. Анхандаа бөө мөргөл болон бурхны шашин нь хурц ширүүн зөрчилтэй байж, монгол үндэстний удамшилт соёл шүтээн болсон бөө мөргөл нь бурхны шашныг гадуурхаж байсан юм. Учир нь монголчуудад авч хэлбэл бурхны шашин бол харь гаралтай соёл болно, гэвч бурхны шашин бол онол сургаалын хувьд нарийн гүнзгий онолын системтэй, зан үйлийн хувьд боловсон журамт ёс горимтой, ухуулал сурталчлын талаар дээд хэмжээгээр боловсруулсан номлох арга хэрэглүүр, бишрүүлэх ур эрдэмтэй байдаг. Иймээс 17 дугаар зууны үед бурхны шашин монгол оронд нийтэд ялгэрч, монголчуудын үзэл ухамсрыг ноёрхсоноос монголчуудын түүх бичлэгт ч нөлөөлж, монголын түүхийг бурхны шашны түүхтэй холбож бичих болсон юм. Даруй түүхчид өөрсдийн түүхэн уламжлал ба бурхны



THE CULTURAL WAY

шашны үзэл ухамсрыг уялдуулан нэгтгэсэн шинэ нэгэн түүхэн хүүрнэлийг үүсгэв. Лу.Алтан товч бол даруй 17-19 дүгээр зууны үеийн бурхны шашны үзэл ухамсар бялхам түүхэн уран зохиолын төлөөлөх бүтээл болно.

(Нэг) Чингисийн дээдсийг бурхны шашинтай холбосон түүхэн хүүрнэл

Лу.Алтан товчид зохиогчоос бурхны шашны түүхийн шашны үзэл ухамсраас үүсэж, монголын түүхэн дэх өдий төдий асуудлын тухай дахин тайлбар хийх гэж чармайн оролдов. 13 дугаар зуунаас өмнөх монголын түүхэн агуулгыг хүүрнэхдээ Монголын нууц товчооны агуулгад суурилсан боловч монгол хүн ба хаадын үүсэл гарлыг бичихдээ Монголын нууц товчооны бичлэгийн аргыг авсангүй, харин монголын түүхэн уламжлалыг энэтхэг төвөдийн бурхны шашны түүхтэй уялдуулж, монголын түүхийг бурхны шашны ертөнцийн түүхийн салж болшгүй нэгэн бүрэлдэхүүн болгосон юм. Юуны урьд Лу.Алтан товчид удам цадигийн талаар монголын хаадын үүслийг эртний энэтхэгийн Маха самадийн “алтан урагтан”-тай холбосон байна. Зохиогч урьдаар энэтхэгийн хаадын үеийг дараалан тоочиж, хүн төрөлхтний үүслийн орь бурхны заяагаар Маха самамди хэмээн алдаршсан, энэхүү хааны хоч үеэс бурхан багшийн үе хүртэл бичив. Өнгөрсний дараа дахин төвөдийн хаадын удам цадигийг өгүүлжээ.

Даруй “Бурхан багш нирваанд нөгчиж мянга илүү жил болсны хойно, Маха самади хааны алтан ургийн хойчис дорно цаст оронд дэлгэрсэн нь ийн буюу. Энэтхэгийн Макад улсын Гүшала хааны хөвгүүн Сарав нэрт хааны отгон хөвгүүний зүс өнгө ер бус болохоор, энэ хөвгүүн төрөлх дутмаг зэмдэг хүүхэд гэж үзээд зэс хайрцагт хийж Гэнгэ (ганга) мөрөнд хаяжээ. Балба (непал), төвөд хоёрын завсар төвөдийн нэгэн өвгөн мөрний хөвөөнөөс хайрцгийг нээж үзвээс гоо үзэсгэлэн нэгэн хөвгүүн ажгуу. Өвгөн энэ хүүхдийг тэжээгээд 16 жил болжээ. Энэ хүүхэд цаст самба уулын дөрвөн харь газар олж нутаглая гэж иртэл, төвөдийн хүн учирч: хаанаас ирэх хүн бэ? гэж асуухлаар, тэр дээшээ заав. Ингэмэгц төвөд хүн түүнийг тэнгэрээс заяат буюу гэж үзээд, хүзүүндээ өргөн авч ирээд хаан өргөв. Тэр бол даруй төвөдийн эн тэргүүн хаан-хүзүүн сандалт хаан билээ. Хожим нь 19 дүгээр зууны үе болоход бурхны шашныг шүтэж эхэлжээ. Дахин таван үе болохуй



Сүнчэнхамба хаан мэндэлснээс хойч бурхны шашин бадран дэлгэрэв”¹ хэмээн хүүрнэсэн байна. Монголын хаадыг бас төвөдийн хаадаас үүсэлтэй болгожээ. Тухайлбал, Лу. Алтан товчид хүзүүн сандалт хааны 7 дугаар үеийн Далай совин алтан сандалт хааны гурван хөвгүүний отгон нь чоно болой. Өөр зуур муудалцаж Бөртэ чоно умар зүг тэнгис далай гэтэлж “зад”-ын газар ирээд Хуа марал нэрт охиныг авч Бурхан халдунаа нутаглаж хойч үржээд монгол овогтон үүнээс бий болов хэмээн тайлбарлаж буй.

(Хоёр) Чингис хааныг бурхны шашинтай холбосон түүхэн хүүрнэл

Монголын нууц товчоонд боржгин овгийн дээдэс Бодончарыг “дээд тэнгэрээс заяасан хөвгүүн” болгон өргөн дээдлэхдээ түүнийг “гэрэл гэгээгээр жирэмсэлсэн” гэж хүүрнэж байснаас 17 дугаар зууны үеийн сурвалж бичиг Лу. Алтан товчид зохиогч төвөдийн хаадын ирэлтийг урьдаар хүүрнэж, дараа нь монголын хаадын удам цадигийг хүүрнэжээ. Гэхдээ Лувсанданзанаар Чингис хааныг шүтэхэд их анхаарал тавив. Тэрээр бурхан нирваанд нөгчиж 3250 илүү жил болсны хойно, Сод богд Чингис хааныг төрөхийн урьд замбуутивийн ертөнцөд 12 муу хаад төрж, хамаг амьтан маш дэнслэн зовоход эрхт Шагимуни бурхан, тэнгэрийн хувилгаан сод богд Чингис хаан төрөх, хамгийг мэдэгч тэр болох буй” хэмээн урьдчилан хүүрнэн тушаажээ. Лувсанданзан уламжлалт бурхны шашны үзэл ухамсраас Чингис хааныг шидчилж, түүнийг алтан хүрдэн эргүүлэгч номын хаан-Чакравади хэмээн өргөн шүтсэн бөгөөд Чингис хаан бол Шагимунийн заавраар хүний ертөнцөд төрсөн эсэр тэнгэрийн хувилгаан мөн хэмээн дээдлэн хүүрнэжээ.

Энэ нь бурхны шашны нөлөөг хүртсэн нь яриангүй. Иймэрхүү хүүрнэл нь монголын түүхэнд Чингис хаан ба алтан урагтны шүтлэгийг бий болгосон билээ. Лувсанданзан Чингис хааныг хувилгаанжуулах ба Чингис хааны алтан урагтны сүр хүчийг нэмэгдүүлэхийн төлөө түүхийн үнэнийг гажуудуулахыг бодсонгүй, зарим үнэн хэрэг учрыг бурхны шашны ойлгомжоор зохиох буюу өөрчилсөн байна. Жишээлбэл,

¹ Тэнгис. Төвөдийн бурхны шашин ба монголчуудын соёл [М], Ляонин ҮнХХ., 2009 т 325-326



Чингисийн есөн өрлөгийн хэлсэн магтаал үгсэд бурхны шашны агуулга ба шашны үгс дүүрэн байна. Боорчийн Чингис хааныг магтсан нь: “Элдэв эрдэнэсээр цогцлоосон сүмбэр уул мину, энд тэндээс олон мөрөн цутгалант анабад далай мэт, өдөр шөнө од гарагаар хүрээлсэн огторгуйн чандмань мину, эрхт тэнгэрийн хөвгүүн сод богд эзэн мину, хаан хүний гучин таван эрдмийг төгс сураад, хас их төр шашин хоёроо алдалгүй түвшин бариад ...”² хэмээх агуулга нь Монголын нууц товчоон дахь агуулгатай адил бус болж хувирсан юм. Энэ нь зохиогчийн амтдарч байсан цаг үе бол бурхны шашин монгол оронд нийтэм дэлгэрэн тархаж, бурхны шашин ноёрхох байр суурийг эзэлж байсантай шууд холбоотой юм.

(Гурав) Чингисийн хойчисыг бурхны шашинтай холбосон түүхэн хүүрнэл

17 дугаар зууны үеийн монгол түүхэн уран зохиолын хүүрнэгдэхүүнээс тухайн үед монгол хаант төрийн хамгийн чухал асуудал бол даруй дотоодын хямрал ба гадаадын тэмцэл болох юм. 17 дугаар зууны үеийн түүхэн уран зохиолын хүүрнэлийн төвлөрөл нь төр шашны хоёр талд тусаж байжээ. Үүнд төрийн талын хүүрнэлд Чингисийн алтан урагтны хаадын үе залгамжийн жагсаалтыг хүүрнэн үзүүлэхийн хамт алтан урагтны бүлгэмдлийн ач холбогдлыг онц товойлгон, дотоодын хямрал ба задралыг илчлэн хүүрнэжээ. Шашны талын хүүрнэлд Чингис хааныг энэтхэгийн Маха самали хааны “эрхин бодисангийн төрөл авсан болгож, Өгэдэй бол энэтхэгийн хааны хөвгүүн, Хубилай хаан бол бурхны төрөл авсан биетэй гэж туурвив. Бурхны шашны монгол газарт дэлгэрсэн түүхийг нэлээд нарийн тодорхой бичиж, эрт язгуураас аваад монголын хаад төр шашин хоёр ёсыг тэгшээр явуулсан гэж сурталчлав. Тухайлбал, Лу. Алтан товчид Хубилай сэцэн хаан зарлиг болсныг хатан сонсож учир шалтгааныг Пагва ламд очиж “Гармаа багшийг эрхин болговоос, Сажагийн язгуур үндсэн гэмт болохын тул, шид хувилгааныг үзүүлэн соёрх” хэмээсэнд “хаан түшмэд эхлэн бүгдийн дунд Пагва лам илдээр өөрөө хийгээд гар хөлийг таван өөр огтолж, таван язгуурт бурхан болгон адислаж үзүүлсэн тэргүүтэн олон хувилгааныг илдний хурим болгон үзүүлжээ. Тэр Хубилай сэцэн хаан нь борсан хуврагуудыг албанаас гаргаад, хоёр ёсыг тэгш зохиож,

² Лувсанданзан зохиож, Чойжи тайлбарласан. Алтан товч [М], ӨМАХХ., 1983 т 348



Чингис хааны их төрийг бататган барьсанаар чигтэнэ сэцэн хаан хэмээн олноо алдаршив”³ гэж Хубилай хаан шашныг дээдэлснээс төр улс амар түвшин болжээ гэж тэмдэглэжээ.

Хоёр. Төр шашин хоёр ёсыг тэгшид явуулахыг чухалчилсан түүх бичлэгийн онцлог

Бурхны шашин монгол оронд тархан дэлгэрсэн нь монголын ноёрхогч ангийн улс төрийн зорилттой холбоотой, монгол хаад ноёд ба шашны дээд давхаргатны хамтын хичээл зүтгэлтэй холбоотой. Монголчууд төвөдийн бурхны шашинтай анх эхлэхдээ улс төрийн шалтгаанаар харьцаатай болсон юм. “Бурхны шашны дэлгэрэлт нь төр ба шашны дээд давхаргатны хамтрал жич шашин төрийг зэргээр мандуулах бодлогоос салж чадаагүй байдаг”⁴. Лу. Алтан товчид Хубилай сэцэн хаанаас төр шашин хоёр ёсыг тэгш явуулснаар Чингис хааны байгуулсан их төрийг бататган хөгжүүлж чаджээ хэмээн хүүрнэжээ.

(Нэг) Төр шашин хоёр ёсыг тэгшид явуулагчдыг магтсан хүүрнэл

Хубилай хаан – Пагва лам

1247 онд монгол хан хөвгүүн Гүдэн монголын Гүег хааны сууринд залгамжлах их хуралд оролцоод буцах замдаа төвөдийн Сажа бандидтай уулзжээ. Хубилай хаан төвөдтэй нөхөрсөг байхаа илтгэхийн төлөө тухай үед төвөдийг ноёрхож байсан Сажагийн бүлгийн төлөөлөгч Сажа банидид Гунгаажалцаны ач хөвгүүн Пагва ламыг хааны ордонд үлдээв. Пагва лам монголын ноёрхогч давхаргыг шашин зүг эвтэй хөтөлснөөс Юань улсын ордныхон ба ноёрхогч давхаргынхан шашны номд орж, Пагва-г “Улсын багш”, “Хааны багш” өргөмжилсөн байна. Пагва лам голдуу төр шашны бүлэг ба төрийн харьцаа жич хааны хувь хүний үзлийн талаар Хубилай хаанд нөлөө үзүүлж байснаас биш үзэл суртал ба шашин суртахууны үзлийн талаар монголчуудын дунд их

³ Лувсанданзан зохиож, Чойжи тайлбарласан. Алтан товч [М], ӨМАХХ., 1983 т 531-532

⁴ Хасгуа. Монгол түүхэн сэдэвлэхүүнт роман ба монголчуудын түүхэн ухамсар [М], ТҮНХХ., 2012 т 87



нөлөө гаргаж чадсангүй. Тухайн үед монголчуудын язгуур шашин бөө мөргөл нь мөн ч чухал байрыг эзэлж байсан юм. 17 дугаар зууны үед бичигдсэн Лу. Алтан товчид тэмдэглэснээр: “Хубилай сэцэн хааны төр шашин хоёр ёсыг тэгшид явуулах төрийн хоёр байгууламжийн дүрэм тогтоолыг чанга тогтоож байсан байна. Бурхны шашин бол бүрэн төгөлдөр системтэй бөгөөд нарийн нямбай шашны онолтой. Шашны сургаалд: “Хүмүүсийн энэ төрлийн баян ядуу нь урд төрлийн үйлийн үрээс болжээ, энэ төрлийн үйлийн үр нь ирэх төрлийн хувь заяаг тогтооно. Хэрэв энэ төрөлдөө нүгэл хийвээс ирэх төрөлдөө тамд унах буюу муу үйлийн гурван зүйлийн амьтан болж төрнө”⁵ гэх мэтээр номлодог. Бурхны шашны эдгээр номлол нь монголын хаадын ноёрхолд ашигтай учраас Хубилай хаан түүгээр төрийг засах жолоодогч үзэл санаа болгож байжээ. Яг иймээс 17 дугаар зууны үед зохиогдсон Лу. Алтан товчид Чингис хааны дээдэс нь энэтхэгийн Маха самади хаан ба төвөдийн хүзүүн суудалт хаанаас үүсэлтэй болохыг “төвөдийн эн тэргүүн хүзүүн суудалт хаанаас салсан далай совин алтан сандалт хааны хөвгүүн нь гурван буюу. Ах нь Буурч, дэд нь Шувууч, отгон нь Бөртэ чоно буюу. Өөр зуураа муудалцаж Бөртэ чоно умар зүг тэнгис далай гэтэлж задын газар ирээд, эр үгүй Хуа марал нэрт охиныг авч задын нутаглан монгол омогтон болов”⁶ гэж тэмдэглэсэн байна. Бурхны шашны түүхийн үзлээр монгол түүхийг хувирган бичиж, бурхны шашны үзлээр монголын төр засгийн үзэгдэл ба асуудлыг тайлбарлажээ. Хубилай хааны үеэс монголын хаад ноёд төр шашин хоёр ёсыг тэгшид явуулахыг сурталчилжээ.

Алтан хаан – Содномжамц

1578 онд Түмэдийн Алтан хаан төвөдийн шарын шашны түрүү Содномжамцийг залж Хөхнуурын Цавчаал сүмд учирсан ба Алтан хаанаар Содномжамцад богд хамгийг мэдэгч Очир дара далай лам гэсэн цол өгч, далай лам алтан хаанд мянган алтан хүрдийг эргүүлэгч Чигиварун сэцэн хаан” хэмээх цол шагнажээ. Ингэж хаан ба лам хар шарын хоёр этгээд хамсаж олон зүйлийн чухал тогтоолуудыг гаргаж бөө мөргөлийг дарангуйлан шарын шашныг ихээр дэлгэрүүлэв. Чин улсын үе хүрээд манжийн ноёрхогчид ч монголчуудын оюун тархийг

⁵ Лю Жиньсуо. Арван буянт номын цагаан түүх [М], ӨМАХХ., 1981 т 59

⁶ Лувсанданзан зохиож, Чойжи тайлбарласан. Алтан товч [М], ӨМАХХ., 1983 т 17



шашнаар минчүүрүүлж, сүм хийдийг олон байгуулж, бурхны ном судрыг олон орчуулж дэлгэрүүлж байжээ. Алтан хаанаас бурхны шашныг дахин дэлгэрүүлснийг Лу. Алтан товчид, “Гэгээн хаан нь Жао сагимуни бурхны бие эрдэнэ алт мөнгөөр байгуулав. Тасарсан шашныг залж эвдэрсэн төр засаж таван өнгө дөрвөн харь улсыг эртний сэцэн хаан мэт алдаршуулав” гэж тэмдэглэсэн байна. Алтан хаан бурхны шашныг монгол оронд дахин дэлгэрүүлсний сүүлээр, монголын бүх аймгийн феодал эзэд ч Алтан хааныг дуурайж, бурхны шашныг шүтэж, шарын шашны хамгийн дээд удирдагч далай ламтай уулзаж, далай ламын тэндээс цол хүртэх болжээ. Халхын ноёды нэг болох Абтай, түмэдийн Алтан хаан шашинд орж нэр алдар нь ихээхэн дэлгэрч байгааг сонсоод өөрийн биеэрээ Алтан хааны нийслэл Хөххотод ирж далай лам Содномжамцтай учирч шарын шашныг Халхад дэлгэрүүлэхээр хэлэлцэн тохирч, далай лам түүнд хан цол өгчээ. Эдгээр нь халхын Абтай ханы шарын шашин шүтэж, бөөгийн шашныг гадуурхаж байсныг тэмдэглэж байна. Монголд хамгийн нөлөөтэй байсан Алтан хаан шарын шашны тусламжаар монголыг эрхэндээ оруулж нэгтгэн захирах бодлогыг тавьж байжээ. Энэ нь Алтан хаан Содномжамц далай лам хоёр Хубилай хаан ба Пагва ламын төр шашин хоёр ёсыг тэгшид явуулсан төрийн бодлогыг цаашид үргэлжлэн хөгжүүлсэн ач тус юм.

(Хоёр) Төр шашин хоёр ёсыг омтгойлогчдыг шүүмжилсэн хүүрнэл

“Хубилай хаанаас Юань улсын эцсийн хаан Тогоонтөмөр хүртэлх хаад төвөдийн орноос лам залж улсын багш болгож байжээ. Ганц Тогоонтөмөр хаанаар төр гүрнийг мөхлийн заяанаас гэтэлгэж чадахгүй болсон улсын багш Гунгаанямбууд уурлаж лам чи өөрийн орондоо ангижрагтун хэмээн хөөснөөс лам хуврагууд төвөдийн орондоо буцжээ”⁷. Үүний дээр Юань улс мөхөхийг дагалдан, бурхны шашин нь төрийн шашны байр сууриа алджээ.

Тогоонтөмөр хаан – Гунгаанямбуу

⁷ Хасгуа. Монгол түүхэн сэдэвлэхүүнт роман ба монголчуудын түүхэн ухамсар [М], ТҮнХХ., 2012 т 84



THE CULTURAL WAY

1333 онд Тогоонтөмөр хаан их ор суув. Их ор суусны дараа жаргалд ташааран архинд орж явдал журмыг алджээ. Чингисийн их төр сулран монголын самуун байдал бий болжээ. “Чингис хаанаас Тогоонтөмөр хаан хүртэл Сажагийн лам нарыг тахив. Ухаант хаан нь тайш ивсүн лү ламын зарлигт эс орж, Пагва ламын тангарагаас давж Хубилай сэцэн хааны барьсан Дайду харшийг алдсан ёс нь ийн буюу: тэр Ухаант хааны цагт, зүрчид өвгөний Жао нэрт хөвгүүнийг төрөхөд гэрээс солонго татав. Тэр бэлгийг Лаган, Ибагу хоёр мэдэж, энэ гэгээн, хаанд маань сайнч тусад буй яа, мууч хорт буй яа, үүнийг өчүүхнээс үгүй болгогтун гэж хаанд өчив. Хаан тэр хоёрын үгэнд эс орж, тэр гэгээнийг эс алав. Лаган, Ибагу хоёр өгүүдрүүн: та үүний эс алав. Үүний хойно тэргүүнээ бүү хэмжлэгтүн”⁸ гэж хүүрнэж Тогоонтөмөр хаан ламын үгийг эс сонсож шашныг олтгойлсноос нэг зуу бөгөөд таван он болсон төрөө алджээ. Тэр нь хятад түшмэл зүгийн үгийг хэтэрхий итгэж, монгол дотно түшмэдийн сэрэмжлэлийг хайхарсангүйд оршно. Тэгснээс сая түмэдийн Алтан хааны үед хүрээд тасарсан шашныг залж, эвдэрсэн төрийг засах болжээ. Лу. Алтан товчид шашин суртахууныг ашиглан монголын хаан төрийг хамгаалж, хааны хүчийг түшиглэж шашин суртахуунаа хамгаалж байсныг хүүрнэв. Монголын төр төвшдөх ба төр самуурах нь бурхны шашныг дэлгэрүүлэх ба чөлөөлөгдөхтэй шууд харьцаатай байдаг. Иймээс шашныг дэлгэрүүлж хүндэтгэж ашиглавал сая төр гүрэн чинь хөгжин мандаж чадна.

ДҮГНЭЛТ

Бурхны шашин нь 17 дугаар зууны үеийн монгол түүхчдийн үзэл санаа ба утга зохиолд ихээр нөлөөлсөн юм. Тэдний монголын түүхийг бичихдээ бурхан шашны түүхийг монгол түүхийн нэгэн хэсэг агуулга болгон, монгол түүхийн явдлыг бас бурхны шашны үзэл номлолоор тайлбарладаг байжээ. Бурхны шашин дэлгэрэн тархаж бөөгийн шашныг орлож төрийн шашин болсон нь хаан төрийн ноёрхлоо хамгаалах шаардлагаас болсон юм. 17 дугаар зууны үеийн Лу. Алтан товч нь тэрхүү ахуй байдлыг тусгаж монголын түүхийг бурхны шашинтай холбогдуулан хүүрнэсэн юм.

⁸ Лувсанданзан зохиож, Чойжи тайлбарласан. Алтан товч [М], ӨМАХХ., 1983 т 540



THE CULTURAL WAY

ABSTRACT

Buddhism greatly influenced the ideas and literature of mongolian historians in the 17th century. When they wrote the history of mongolia, they explained the history of buddhism as a part of mongolian history, and the events of mongolian history were also explained by the teachings of buddhism. The buddhism spread widely and replaced shamanism and became the state religion due to the king's need to protect his sovereignty. 17th century The Lu. Altan tobči reflects that situation and narrates the history of Mongolia in relation to the buddhism.

Keywords: *The Lu. Altan tobči, buddhism, effect*



ХӨХНУУРЫН ЧУУЛГАНЫ ЦААЗЫН БИЧИГ
ХИЙГЭЭД
САЙН ҮГТ ЭРДЭНИЙН САН НЭРТ ШАСТИР-ТАЙ
ТОХИРОЛЦОХ ХЭСГИЙН ҮСГИЙН БИЧЛЭГИЙГ ХАРЬЦУУЛАН ШИНЖЛЭХ НЬ

Аруухан*

ХУРААНГУЙ

17 дугаар зууны үед зохиогдсон монгол сурвалж бичиг “Хөхнуурын чуулганы цаазын бичиг” ба Зууннаст нарын зохиосон 14 дүгээр зууны Сономкара-ийн орчуулгын хуулбар бүтээл “Сайн үгт эрдэнийн сан нэрт шастир”-ын тохиролцох хэсгийн агуулга нийт таван хэсэгт байж, тус тус (26a:6-26a: 7) лугаа тохиролцох (VII-11b), (27b:5-27b:6) лугаа тохиролцох (IV-5b), (28a:10-28b:2) лугаа тохиролцох (V-2b), (31a:4-31a:6) лугаа тохиролцох (V- 4b), (32b:8-32b:10) лугаа тохиролцох (II-5b) болно. Хэдийгээр тохиролцох хэсгийн агуулга нь адил боловч үсгийн бичлэг нь өөр өөрийн онцлогтой байдаг. Тус өгүүлэлд өгүүлэн буй хоёр сурвалж болон түүнээс хожуу үеийн буриад орчуулгын бүтээл зэрэг гурван сурвалж бичигт илэрсэн тохиролцох хэсгийн үсгийн бичлэгийг хооронд нь харьцуулан шинжлэхээр дамжин, бүх сурвалж бичиг дэх үсгийн бичлэгийн өвөрмөц онцлог болон адил бус цаг үеийн монгол үсгийн бичлэгийн онцлог шинжийг тодруулан илрүүлэхийг хичээв.

Түлхүүр үгс: *Хөхнуурын чуулганы цаазын бичиг, Сайн үгт эрдэнийн сан нэрт шастир, буриад орчуулгын бүтээл, үсгийн бичлэг*

“Хөхнуурын чуулганы цаазын бичиг” (доош Цааз бичиг гэж товчилно) бол 17 дугаар зууны үед зохиогдсон монголын эртний хууль цаазын дурсгалт бичгийн нэг болно. Уг эхийг Гү.Цэрэнбал 1997 оны 1 сард одоогийн Хөхнуур мужийн Улаан шянь-ий данс эвхмэлийн товчооны Д.Мөнх нөхрөөс олжээ. Тус эх дэвтэр нь хулсан үзгээр

* Өвөр Монголын Их Сургуулийн Монгол Судлалын Дээд Сургуулийн 2022 оны магистрант



THE CULTURAL WAY

бичигдэж, үсгийн хэв ба тиг зурлага нь жигд тодорхой байдаг. Энэхүү цааз бичиг бол Дөрвөн Ойрадын Хошууд аймгийн Гэгээн Гүүш хан 1637 оноос аймаг албатаа дагуулан Хөхнуур Төвөдийн өндөрлөгт орж ирээд 48 жил болсны дараа, 1685 онд Хөхнуурын чуулган дээр тунгаан баталсан бичиг болно. Уг эх нь нийт 64 нүүр 32 хуудастай, нэг нүүр нь 10 мөрөөр жагсаагджээ. Эдүгээ бидэнд олдсон эх нь бүрэн бүтэн биш, харин өмнө хэсгийн 44 нүүр, 22 хуудас нь урагдаж шатаагдаад тасархай тамтархай хэсэг л үлджээ. Сүүлийн хэсгийн 20 нүүр, 10 хуудас нь бүрэн бүтнээрээ байна¹.

“Сайн үгт эрдэнийн сан нэрт шастир” (бас Субашид гэнэ)бол 13 дугаар зууны үеийн төвөдийн алдарт эрдэмтэн Сажа бандид Гунгаажалцаны чухал бүтээл болно. Түүний анхны орчуулга бол Сономкара-ийн орчуулга юм. Тус өгүүлэлд Зууннаст нарын зохиосон 14 дүгээр зууны үеийн хуулбар бүтээл “Са-ийн үгт эрдэнийн сан нэрт шастир” (доор Шастир гэж товчилно) болон 19 дүгээр зууны үеэр буриад Номтын Ринчиний орчуулсан “Сайн номлолт эрдэнийн сан Субашидын тайлбар сангийн бүтээл” (доор Буриад орчуулга гэж товчилно) гэх хоёр сурвалж бичгийг ашиглаж, Цаазын бичигтэй тохиролцох таван хэсгийн агуулгад илэрсэн үсгийн бичлэгийг харьцуулсан шинжилжээ. Хэдийгээр тохиролцох хэсгийн агуулга нь ерөнхийдөө адил боловч тэмдэглэсэн үсгийн бичлэг нь өөр өөрийн онцлогтой байдаг. Иймээс адилхан нэг хэсэг агуулгыг адил бус цаг үеийн бүтээлд адил бус үсгийн бичлэгээр бичсэн байдлыг харьцуулан шинжлэх нь адил бус цаг үеийн монгол үсгийн бичлэгийн онцлогийг тодруулж чадахаар барахгүй, бас бүх сурвалж бичигт илэрсэн үсэг бичгийн өвөрмөц онцлогийг илрүүлж чадна. Доор, дээрх сурвалж бичгүүдэд илэрсэн монгол үсгийн бичлэгийн тухай титэм толгойн онцлог, үсгийн сүүлийн онцлог болон ялгах дуслын онцлог зэрэг гурван талаас харьцуулан өгүүлье.

Нэг. Титэм толгойн онцлог





Тус хэсэгт гурван сурвалж бичигт илэрсэн монгол үсгийн эгшиг үсгийн титмийн бичлэгийн хэлбэр болон гийгүүлэгч үсэг n, b, q, γ, g, k,












¹ Гү.Цэрэнбал. Хөхнуурын чуулганы цаазын тухай анхны шинжилгээ. ӨМЭШС., 2003 №3










m, l, s, š, t, d, č, j, y зэргийн толгойн тэмдгийн бичлэгийн хэлбэрүүдийг жишээтэй харьцуулан өгүүлэхээр дамжин тэдгээр бичлэгүүдийн өвөрмөц онцлог болон нийтлэг онцлогийг тодруулан илрүүлжээ.

1. Эгшиг үсгийн титмийн онцлог

Цаазын бичигт илэрсэн эгшиг үсгийн титэм нь “” хэлбэрээр илэрчээ. Жишээлбэл:  aldar (27b:5),  ücū-ken (32b:8),  üje (32b:9).







Шастирт Цаазын бичигтэй тохиролцох хэсгийн агуулгад илэрсэн эгшиг үсгийн титмийн бичлэг нь “” хэлбэрээр илэрчээ. Жишээлбэл:  aldar (IV-5b),  ücūken (II-5b),  üjetkūn (II-5b). Хоёр сурвалж бичигт илэрсэн титмийн тухай харьцуулбал, Цаазын бичигт илэрсэн эгшигийн титмийн зурлага маш тодорхой бичигдсэн мөртөө “” титмийн дээр үзүүрт зүүн тийш чиглэлтэй богино ташууг залгаж, “” хэлбэрээр илэрсэн нь тус сурвалж бичгийн үсэг бичгийн өвөрмөц онцлог болно. Харин Шастирт Цаазын бичигтэй тохиролцох хэсгийн агуулгад илэрсэн “” хэлбэр нь уйгуржин монгол үсгийн сурвалж бичигт бас илэрчээ. Жишээлбэл:  abubasu (). Шастираас хожуу үеийн бүтээл болох түүний буриад орчуулгын тохиролцох хэсэгт илэрсэн эгшиг үсгийн титэм “” хэлбэрээр илэрчээ. Жишээлбэл:  ücūken. Тус бүтээлд илэрсэн эгшиг үсгийн титэм өнөөгийн монгол үсгийн бичлэгтэй нэгэнт адил хэлбэрээр бичигдэх болжээ.










2. Гийгүүлэгч үсгийн толгойн тэмдэг








(n) гийгүүлэгчийн толгойн тэмдэг - Цаазын бичигт n гийгүүлэгч толгойн тэмдэг “” хэлбэрээр илэрч, үндсэн бичлэгийн хувьд эгшиг үсгийн титмийн зурлагатай адил бичигджээ. Жишээлбэл:  nige (29a:9),  noqai (27b:6). Шастирт Цаазын бичигтэй тохиролцох хэсгийн агуулгад илэрсэн n гийгүүлэгчийн толгойн тэмдэг “” хэлбэрээр илэрчээ. Жишээлбэл:  noqai-a (IV-5b). Үүнд n гийгүүлэгч дусалгүй хэлбэрээр илрэв. Буриад орчуулгын бүтээлд n гийгүүлэгчийн толгойн бичлэг нь дусалтай “” хэлбэрээр илэрчээ. Жишээлбэл:  noqai.







THE CULTURAL WAY

(b) гийгүүлэгчийн толгойн тэмдэг - Цаазын бичигт *b* гийгүүлэгчийн толгойн тэмдэг “” хэлбэрээр түгээмэл илэрчээ. Жишээлбэл:  bosud (27b:6). Шастирт Цаазын бичигтэй тохиролцох хэсгийн агуулгад илэрсэн *b* гийгүүлэгч “” хэлбэрээр илэрчээ. Жишээлбэл:  bosud (IV-5b) тус дүрс нь уйгуржин монгол үсгийн сурвалж бичигт мөн түгээмэл илэрнэ. Харин буриад орчуулгын бүтээлд “” хэлбэрээр илэрч, тэр нь Цаазын бичигт илрэх хэлбэртэй адилавар, цөм оройн хэсэгтээ богино шулуунтай бичигджээ. Жишээлбэл:  bosud.

(q, γ) гийгүүлэгчийн толгойн тэмдэг - Цаазын бичигт илэрсэн *q, γ* гийгүүлэгчийн толгойн тэмдэг “” хэлбэрээр түгээмэл илэрчээ. Жишээлбэл:  qucan (27b:3),  γayca (32b:8). Шастирт Цаазын бичигтэй тохиролцох хэсгийн агуулгад илэрсэн *q, γ* гийгүүлэгчийн толгойн тэмдэг “” хэлбэрээр илэрчээ. Жишээлбэл:  qucaγdabasu (IV-5b),  γaycaqan (II-5b). Буриадын орчуулгад *q, γ* гийгүүлэгчийн толгойн титэм “” хэлбэрээр илэрчээ. Жишээлбэл:  quciγdabasu,  γaycaqan. Цаазын бичиг болон Шастирт илэрсэн *q, γ* гийгүүлэгчийн толгойн тэмдэг адилавар бичигдэж, буриад орчуулгад илэрсэн *q, γ* гийгүүлэгчийн толгойн тэмдгийг дээрх хоёр бүтээлд илэрсэн хэлбэртэй харьцуулбал *q, γ* гийгүүлэгчийн хомбогор толгой нь баруун дээш чиглэлээр гүдийсэн онцлогтой бичигджээ.

(g, k) гийгүүлэгчийн толгойн тэмдэг - Цаазын бичигт илэрсэн *g, k* гийгүүлэгчийн толгойн тэмдэг “” хэлбэрээр илэрчээ. Жишээлбэл:  (32b:8). Шастирт Цаазын бичигтэй тохиролцох хэсгийн агуулгад *g, k* гийгүүлэгчийн толгойн тэмдэг “” хэлбэрээр илэрчээ. Жишээлбэл:  kürgesü (II-5b). Тус хэлбэр нь уйгуржин монгол үсгийн сурвалж бичигт олон илэрнэ. Жишээлбэл:  gegegen. Буриад орчуулгад *g, k* гийгүүлэгчийн толгойн тэмдэг “” хэлбэрээр илэрчээ. Жишээлбэл:  kürgebesü.

(m, l) гийгүүлэгчийн толгойн тэмдэг - Цаазын бичигт илэрсэн *m* болон *l* гийгүүлэгчийн толгойн тэмдэг “” болон “” хэлбэрээр илэрчээ. Жишээлбэл:  mongqay (27b: 5),  lüge (32b:9). Шастирт Цаазын бичигтэй тохиролцох хэсгийн агуулгад *m* болон *l*



THE CULTURAL WAY

гийгүүлэгчийн толгойн тэмдэг “” болон “” хэлбэрээр илэрчээ. Жишээлбэл: mongqa γ (IV-5b), luγ - a (II-5b). Буриад орчуулгад m болон l гийгүүлэгчийн толгойн тэмдэг тус тус “”, “” хэлбэрээр илэрчээ. Жишээлбэл: mcngqay, luγ-a.

(s, ś) гийгүүлэгчийн толгойн тэмдэг-Цаазын бичигт илэрсэн s, ś гийгүүлэгчийн толгойн тэмдэг “” болон “” хэлбэрээр илэрчээ. Жишээлбэл: sayid (30b:8), šayjaj-a (šayajajai) (31a:5). Шастирт Цаазын бичигтэй тохиролцох хэсгийн агуулгад s, ś гийгүүлэгчийн толгойн тэмдэг “” хэлбэрээс ялгагдана. Буриад орчуулгын бүтээлд s гийгүүлэгчийн толгойн тэмдэг баруун тийш чиглэлтэй богино шулуунаар эхэлсэн “” хэлбэрээр илэрсэн байна. Жишээлбэл: sayid, энэ нь өнөөгийн монгол үсгийн бичлэгийн онцлогтой нэлээд адилавар болжээ.

(t, d) гийгүүлэгчийн толгойн тэмдэг - Цаазын бичигт илэрсэн t, d гийгүүлэгчийн толгойн тэмдэг “” болон “” хэлбэрээр илэрчээ. Жишээлбэл: tusa (32b:8), du (29b:5). Үүнд “” хэлбэрт илэрсэн толгойн хэсгийн урт шулуун нь маш онцлогтой. Шастирт Цаазын бичигтэй тохиролцох хэсгийн агуулгад t, d гийгүүлэгч “”, “” хэлбэрээр илэрчээ. Жишээлбэл: tusa (II-5b), degen (V-2b). Тус дүрс нь уйгуржин монгол үсгийн сурвалж бичигт мөн илэрнэ. Жишээлбэл: todqur. Буриад орчуулгын тохиролцох хэсгийн агуулгад илэрсэн илэрсэн t, d гийгүүлэгчийн толгойн тэмдэг “” болон “” хэлбэрээр бичигджээ. Жишээлбэл: tusa, deki. Тус сурвалж бичигт илэрсэн t, d гийгүүлэгчийн толгойн тэмдэг нь зүүнш махигар оройтой бичигджээ.

(č, j, y) гийгүүлэгч толгойн тэмдэг-Цаазын бичигт илэрсэн č гийгүүлэгчийн толгойн тэмдэг “” хэлбэрээр, j гийгүүлэгчийн толгойн тэмдэг “”, “” хэлбэрээр, y гийгүүлэгчийн толгойн тэмдэг “” хэлбэрээр тус тус илэрчээ. Жишээлбэл: čiglegür (28b:7), juil (28b:4), juljayan (31a:5), yeke (28a:1). Шастирт Цаазын бичигтэй тохиролцох хэсгийн агуулгад č гийгүүлэгчийн толгойн тэмдэг “” хэлбэрээр илэрч, j болон y гийгүүлэгчийн толгойн тэмдэг “” хэлбэрээр



илэрчээ. Жишээлбэл: cīqul (V-4b), juljiyan (V-4b), yeke (V-4b). Буриад орчуулгын бүтээлд ё гийгүүлэгчийн толгойн тэмдэг “” хэлбэрээр илэрч, ј болон у гийгүүлэгчийн толгойн тэмдэг “” хэлбэрээр илэрчээ. Жишээлбэл: cīqul, jarudasun, yeke. Цаазын бичигт ј гийгүүлэгчийн үгийн эхэнд орох дүрсийг у гийгүүлэгчийн үгийн эхэнд орох дүрсээс ялгахын төлөө өмнө нь дусал тавьж тэмдэглэсэн байна. Шастир болон буриад орчуулгын бүтээлд ј болон у гийгүүлэгчийн үгийн эхэнд орох дүрсийг тодорхойлон ялгасангүй, адил хэлбэрээр тэмдэглэн бичжээ. Буриад орчуулгын бүтээлд илэрсэн ё, ј болон у гийгүүлэгчийн толгойн тэмдэг цөм баруун доош чиглэлтэй богино шулуунаар оройн тэмдэг болгон бичсэн нь бусад хоёр бүтээлд илрэх хэлбэрээс ялгагдана.







Хоёр. Үсгийн сүүлийн онцлог







Тус хэсэгт голдуу гурван сурвалж бичигт илэрсэн үсгийн болон гийгүүлэгч үсгийн орхиц, цацалга болон үгийн адагт орсон γ, g, l, s гийгүүлэгч үсгийн бичлэгийн онцлогуудыг тус тусад нь жишээтэй өгүүлснээр барахгүй гурван сурвалж бичигт илэрсэн эгшиг гийгүүлэгч үсгийн сүүлийн бичлэгийн онцлогийг хооронд нь харьцуулан шинжилжээ.






1. Орхиц ба цацалгын онцлог





Өнөөгийн монгол бичигт үгийн эцэстээ орох “ , ” хэлбэрийг орхиц болон цацалга гэнэ. Цаазын бичиг болон Шастирт илэрсэн орхиц, цацалгын бичлэг нь өөр өөрийн онцлогтой байдаг. Цаазын бичигт орхиц ба цацалга голдуу “ , ” хэлбэрээр илэрч, өнөөгийн монгол бичлэгтэй нэлээд ойролцоо бичигдэх болжээ. Жишээлбэл: qoin-a (27b:5), arγ-a (24b:4), öggügsen (28a:4), luγ-a (24a:9). Шастирт Цаазын бичигтэй тохиролцох хэсэгт илэрсэн орхиц “ , ” мэт хоёр хэлбэр байж, хоёр дүрсийн ялгагдах онцлог гэвэл “ ” дүрс нь хөндлөн ба хөндлөнгийн үзүүрээс баруун доош чиглэлтэй ташуугаар төгсөж, “ ” дүрс нь баруун доош чиглэлтэй ташуугийн доор үзүүрийг доош махийлгаж бичжээ. Эхний дүрс нь Шастирт ихэнхдээ тохиолдож, хойнох дүрс нь зөвхөн “өгсөн” гэх үгэнд илэрчээ. Тухайлбал, boyta






(IV-5b),  juljiyan (V-4b),  ögügen (II-5b). Шастирт Цаазыг бичигтэй тохиролцох хэсгийн агуулгад илэрсэн цацалга “ ,  , ” мэт гурван хэлбэр бий. Үүнд “” хэлбэр нь харьцангуй олон илэрчээ.



Жишээлбэл:  qoin-a (V-2b),  tus-a (V-4b),  noqai-a (IV-5b),  aru-a (V-2b)⁸,  eke (V-4b). “” хэлбэр нь зөвхөн “лугаа”

гэх үгэнд илэрчээ. Тухайлбал,  lu-a (II-5b). Хураангуйлбал: Цаазын бичиг болон Шастирт илэрсэн орхиц цацалгын бичлэг адил бус байдаг. Үүнд Цаазын бичигт илэрсэн орхиц цацалгын бичлэг нь харьцангуй тогтворжсон “ , ” хоёр хэлбэрээр нэгдэлтэй илэрч, өнөөгийн монгол үсгийн бичлэгтэй нэлээд адилавар болжээ. Гэвч Шастирт илэрсэн орхиц цацалгын дүрсэд дундад зууны монгол хэлний сурвалж бичигт үргэлж тохиолддог “” болон “” дүрстэй адилавар бичигдсэн





“ , ” дүрс илэрчээ. Жишээлбэл:  taqir-a,  nigen-e



(уйгуржин)². Тус хоёр сурвалж бичигт босоо сүүлтэй орхиц цацалга илэрсэнгүй. Харин түүнээс хожуу үеийн бүтээл болох буриад орчуулгын бүтээлд Шастирт илэрдэг дүрсүүд цөм харагдахаа больж, Цаазын бичигт илэрдэг дүрстэй адилавар бичигдсэн байна. Даруй “”,




“” хоёр дүрс болно. Жишээлбэл:  boyta,  lu-a. Гэвч

Цаазын бичигт илэрсэн орхицын сүүл нь дээш ассан шиг эртийлгэж зурсан “” хэлбэрээр илэрсэн байхад, буриад орчуулгын бүтээлд харин орхиц хэлбэртэй “” дүрсээр бичигдэх болжээ.

2. Үгийн адагт орсон ү, г гийгүүлэгч үсгийн онцлог


Цаазын бичиг ү болон г гийгүүлэгч үгийн эцэст голдуу “” болон “” хэлбэрээр илэрдэг. Жишээлбэл:  mongqay (27b:5),  bilig (24a:9).

Шастирт Цаазын бичигтэй тохиролцох хэсгийн агуулгад үгийн эцэст орсон ү гийгүүлэгч “” хэлбэрээр илэрч, г гийгүүлэгч “”




хэлбэрээр илэрчээ. Жишээлбэл:  mongqay (V-2b),  sesig (VII-11b). Үндсэн бичлэгийн хувьд тус хоёр бүтээлд илэрсэн үгийн эцэст орох ү гийгүүлэгч адил бичигдэнэ. Жаахан ялгаатай тал гэвэл Шастирт илэрсэн “” хэлбэрийн сүүлийн жаахан баруун доош чиглэлээр татаж,

² Ван Гүйрун. Монгол үсэг бичгийн бүтцийн судлал. ЛяоҮнXX., 2012









Цаазын бичигт илэрсэн “**ᠡ**” дүрсийн сүүлийн тэмдгийг баруунш хөндлөн чиглэлээр татсанд бий, **g** гийгүүлэгчийн бичлэгийн хувьд Цаазын бичигт илэрсэн хэлбэр нь өнөөгийн монгол бичигт илрэх хэлбэртэй нэлээд ойролцоо бичигдэж, Шастирт илэрсэн хэлбэр нь уйгуржин монгол үсгийн онцлогийг хадгалж байна. Жишээлбэл:  yutumšiy (уйгуржин).

3. Үгийн адагт орсон **l** гийгүүлэгч үсгийн онцлог

Цаазын бичигт **l** гийгүүлэгч үгийн адагт “**ᠯ**” хэлбэрээр илэрчээ. Жишээлбэл:  qudal (26a:6). Шастирт Цаазын бичигтэй тохиролцох хэсгийн агуулгад илэрсэн **l** гийгүүлэгч үгийн эцэст “**ᠯ**” хэлбэрээр илэрчээ. Жишээлбэл:  qudal (VII-11b). Үүнд Шастирт илэрсэн **l** гийгүүлэгчийн үгийн адагт орох “**ᠯ**” хэлбэр нь уйгуржин монгол үсгийн сурвалж бичигт мөн түгээмэл илэрнэ. Жишээлбэл:  yabudal.

4. Үгийн адагт орсон **s** гийгүүлэгч үсгийн онцлог

Цаазын бичигт **s** гийгүүлэгч үгийн адагт “**ᠰ**” хэлбэрээр илэрчээ. Жишээлбэл:  ulus (31b:4). Шастирт үгийн адагт орсон **s** гийгүүлэгч “**ᠰ**” хэлбэрээр илэрчээ. Жишээлбэл:  bars (V-2b),  činadus (VII-11b). Цаазын бичиг болон Шастирт илэрсэн **s** гийгүүлэгчийн үгийн адагт орсон үсгийн сүүл нь адил бус хэлбэрээр илэрчээ, **s** гийгүүлэгчийн үгийн адагт орох тус хоёр хэлбэр нь монгол сурвалж бичигт түгээмэл илэрнэ. Жишээлбэл:  bars,  ečüs (уйгуржин). Гэвч Шастирт илэрсэн “**ᠰ**” хэлбэрийг уйгуржин монгол үсгийн сурвалж бичигт илрэх “**ᠰ**” хэлбэртэй харьцуулбал, хэдийгээр бүр ташуугаас бүтсэн ч ташуугийн бичлэгийн хувьд ялгаатай байдаг. Уйгуржин монгол үсэгт илрэх “**ᠰ**” хэлбэр нь богино шулууны доор баруун чиглэлтэй ташууг шууд залгаж бичсэн байна, гэвч Шастирт илэрсэн “**ᠰ**” хэлбэр нь зүүнш доош чиглэлтэй богино ташуугийн доор баруун доош чиглэлтэй ташууг залгаж бичсэн байна. Энэ бол тус сурвалж бичгийн өвөрмөц онцлог юм. Шастираас хожуу үеийн бүтээл болох буриад орчуулгын бүтээлд үгийн эцэст орох **s** гийгүүлэгч мөн ташуугаар бичигдсэн боловч харин ташууг баруун тийш чиглэлээр зурсан “**ᠰ**” хэлбэрээр илэрчээ. Жишээлбэл:  bars. Дээрхийг хураангуйлбал, Цаазын бичигт илэрсэн эгшиг гийгүүлэгч титэм, толгойн тэмдэг буюу









үсгийн сүүлийн илэрсэн хэлбэрт уйгуржин монгол үсгийн хэлбэр маш цөөн байж, өнөөгийн монгол бичгийн хэлбэртэй маш адилавар бичигдсэн байна. Энэ нь тус сурвалж бичиг хэдийгээр 17 дугаар зууны үед зохиогдсон боловч түүнийг хуулсан нь нэлээд хожуу үе болохыг харуулж байна. Харин Шастирт илэрсэн хэлбэрт уйгуржин монгол үсгийн сурвалж бичигт илэрдэг онцлог шинж илүү хадгалагдаж байна.

Гурав. Ялгах дуслын онцлог



Тус хэсэгт дээрх монгол сурвалж бичгүүдэд илэрсэн *п*, *q*, *γ*, *š* зэрэг дөрвөн гийгүүлэгчийн дусалтай эсэх хэлбэрийн илэрсэн байдлын тухай жишээтэй тодорхойлон өгүүлжээ.

1. *п* гийгүүлэгчийн дуслын тухай

Цаазын бичигт *п* гийгүүлэгч дусалтай бичигдэх болон дусалгүй бичигдэх хоёр хэлбэрээр илэрсэн боловч дусалтай бичигдэх хэлбэр нь харьцангуй олон илэрчээ. Шастирт Цаазын бичигтэй тохиролцох хэсгийн агуулгад илэрсэн *п* гийгүүлэгч мөн дусалтай бичигдэх ба дусалгүй бичигдэх хоёр хэлбэрээр илэрчээ. Үүнд дусалтай бичигдэх үзэгдэл нь зөвхөн “чанадас, үнэн” гэх хоёр үгэнд илэрсэн байна.




Жишээлбэл:  noqai-a (IV-5b),  nigen (V-2b),  unun (IV-5b),  nemlegsen (V-2b),  činadus (VII-11b),  ünen (VII-11b).

Гэхдээ дусалтай бичигдсэн хоёр жишээ нь цөм үгийн дунд орох *п* гийгүүлэгчид илэрчээ. Цаазын бичигт илэрсэн *п* гийгүүлэгчийн дусалтай бичигдэх хэлбэр нэлээд түгээмэл илэрсэн мөртөө дэвсгэр үсэгт хүртэл бүр дусал нэмэх зуршилтай байв. Гэвч буриад орчуулгын бүтээлд *п* гийгүүлэгч цөм дусалтай хэлбэрээр илэрсэн юм. Жишээлбэл:


 unun,  noqai.

2. *q*, *γ* гийгүүлэгчийн дуслын тухай



Цаазын бичигт *q* гийгүүлэгч дусалгүй хэлбэрээр илэрч, *γ* гийгүүлэгч мөн дусалтай болон дусалгүй хоёр хэлбэрээр илэрсэн боловч дусалгүй бичигдэх дүрс нь харьцангуй олон тохиолддог.

Жишээлбэл:  šaycaγ-a (31a:5),  juljayan (31a:5),  mongqay (27b:5). Цаазын бичиг болон Шастиртай тохиролцох хэсгийн агуулгад *q* болон *γ* гийгүүлэгч дусалгүй хэлбэрээр илэрчээ. Жишээлбэл:



ᠰᠢᠶᠠᠵᠢᠶᠠᠢ (V- 4b), ᠵᠢᠯᠵᠢᠶᠠᠨ (V-4b), ᠮᠣᠩᠭᠠᠶ (V-2b). q, γ гийгүүлэгчид дусал бичих эсэхийн тухай уйгуржин монгол үсгийн цаг үеэс эхлэн сонгодог бичгийн цаг үе хүртэл нийтэм тогтворжоогүй байв. “q гийгүүлэгчид дусал бичих зарчим 13-18 дугаар зууны сурвалж бичигт цөм илэрчээ”³ жишээлбэл: Гэсэрт  (бух)⁴ гэх үгэнд дусалтай хэлбэрээр бичигджээ. Гэвч Цаазын бичигт илэрсэнгүй. Шастирт Цаазын бичигтэй тохиролцох хэсгийн бичлэг болон түүнээс хойно бий болсон буриад орчуулгын бүтээлд, q, γ гийгүүлэгчид дусалтай бичих хэлбэр цөм илэрсэн байна.

3. ᠰ гийгүүлэгчийн дуслын тухай

Цаазын бичигт ᠰ гийгүүлэгч дусалтай бичигдэх хэлбэрээр илэрчээ. Жишээлбэл:  ᠰᠠᠶᠠᠴᠠᠭ-a (31a:5). Цаазын бичиг болон Шастиртай тохиролцох хэсгийн агуулгад ᠰ гийгүүлэгч дусалгүй хэлбэрээр илэрчээ. Жишээлбэл:  ᠰᠢᠶᠠᠵᠢᠶᠠᠢ (V-4b). ᠰ гийгүүлэгч дусалтай болон дусалгүй хэлбэр уйгуржин монгол үсгийн сурвалж бичгээс сонгодог бичгийн цаг үе хүртэл цөм оршиж байв. Үүнд Цаазын бичигт илэрсэн ᠰ гийгүүлэгчид дусал идэвхтэй бичигдэж, Шастирт илэрсэн ᠰ гийгүүлэгчид дусал бичихгүй хэлбэр түгээмэл илэрчээ. Дээрхийг хураангуйлбал, Цаазын бичигт илэрсэн n, γ гийгүүлэгчид дусалтай болон дусалгүй хэлбэр цөм илэрсэн боловч n гийгүүлэгч дусалтай бичигдэх үзэгдэл маш түгээмэл илэрч, γ гийгүүлэгч дусалгүй бичигдэх үзэгдэл харьцангуй олон илэрчээ. Шастирын Цаазын бичигтэй тохиролцох хэсгийн агуулгад n гийгүүлэгч мөн дусалтай болон дусалгүй хоёр хэлбэрээр илэрсэн боловч дусалгүй хэлбэр нь олон хэрэглэгджээ. Үүнээс гадна, γ гийгүүлэгч бас дусалгүй бичигдэх хэлбэр илэрчээ, q гийгүүлэгч хоёр сурвалж бичигт цөм дусалгүй хэлбэрээр илэрчээ, ᠰ гийгүүлэгч дусалтай бичигдэх хэлбэр Цаазын бичигт тун олон илэрсэн байхад, Шастирын Цаазын бичигтэй тохиролцсон хэсэгт дусалгүй хэлбэрээр илэрчээ.

³ Хасчимэг. Бээжин барын Гэсэрийн туужийн хэлний судалгаа. ӨМИС., 2015

⁴ Хасчимэг. Бээжин барын Гэсэрийн туужийн хэлний судалгаа. ӨМИС., 2015



THE CULTURAL WAY

ДҮГНЭЛТ

17 дугаар зууны монгол сурвалж бичиг Цаазын бичиг болон 14 дүгээр зууны хуулбар бүтээл болох Шастир жич түүний хожуу үеийн орчуулгын бүтээлүүдэд илэрсэн монгол үсгийн бичлэг нь нэлээд зөрүүтэй мөртөө бүр тус тусдаа тухайн үеийн монгол үсгийн онцлог шинжийг илэрхий харуулж байна. Үүнд Цаазын бичиг дэх үсэг бичигт нэг талаар сонгодог монгол хэлний үеийн монгол үсгийн онцлог нэлээд илэрхий болсон бөгөөд нөгөө талаар үсгийн зурлагын хувьд маш илэрхий өвөрмөц онцлогтой юм. Шастирт илэрсэн монгол үсгийн зурлагад харин уйгуржин монгол үсгийн онцлог шинж илэрхий олон хадгалагдаж байгаа боловч зарим бичлэг зурлага дээр мөн өвөрмөц онцлогтой хэлбэр илэрч байна. Харин Шастирын 19 дүгээр зууны буриад орчуулгын бүтээлд илэрсэн үсгийн зурлага нь орчин цагийн монгол хэлний үсгийн бичлэгтэй нэлээд адилавтар бичигдэх болжээ.

ABSTRACT

The records of the Mongolian script found in the late translation works of the 17th-century Mongolian manuscript of the *Čayaja yin bičig* and the 14th-century copy of the *Šastir* and clearly show the characteristics of the Mongolian script of that time, although each line is quite different. On the one hand, the characteristics of the Mongolian alphabet during the classical Mongolian language are quite evident in the alphabet of *Čayaja yin bičig*'s script, and on the other hand, it has a very obvious unique feature in terms of calligraphy. In the Mongolian writing found in the chronicles, many features of the Uyiurjin Mongolian writing are clearly preserved, but some of the written writings also have a unique form. However, the inscriptions found in the 19th-century Buriat translation of *Šastir* are very similar to the writings of the modern Mongolian language.

Keywords: *Čayaja yin bičig*, *Šastir*, *Buriad translation*, *writing word*



ДУЛААНЫ ӨГҮҮЛЛЭГ ДЭХ “ЗОЛИОСНЫ ХОНЬ 替罪羊” ГЭХ УР ЗАГВАРЫН
ТАЙЛАЛ

-“Тэнэг үнэг алга болсон нь” гэх өгүүллэгийн жишээн дээр

Гоёонч*

ХУРААНГУЙ

Тэнэг үнэг алга болсон нь (傻子乌尼戈消失了) бол Дулааны анхдагч өгүүллэгийн түүвэр байж, түүвэрт байгаа Тэнэг үнэг алга болсон нь гэх өгүүллэгт зохиолын гол баатар тэнэг үнэгний гурван удаагийн сураг тасарсан ба гурван удаагийн дахин илэрсэн гэх гол сэжмээр үлгэрийн үйл явдлыг хэрхэн холбож, үнэг гэгч золиосны хонины дүрийг зураглан бүтээсний хамт хүн чанарт нуугдаж байгаа муу муухай талыг илчилсэн байна. Энэ нь өрнө дахины золиосны хонь гэх ур загвар (原型)-ын хувилбар хэмээн хэлж болно. Тус өгүүлэлд Фрейн ур загварын онолыг ашиглан Дулааны “Тэнэг үнэг алга болсон нь” гэх өгүүллэгт илэрсэн золиосны хонины ур загварыг шинжлэн, энэхүү ур загварын ард нуугдсан хүн чанарын тухай асуудал, аль эсвэл энэ өгүүллэгийн тусгах гэсэн утга санааны тухай товч өгүүлжээ.

Түлхүүр үгс: *Дулааны өгүүллэг, золиосны хонь, ур загварны онол, хүн чанар*

Дулаан, ӨМӨЗО-ы Тунляо хотын Хүрээ хошууны хүн. Өвөр Монголын Их Сургуульд суралцаж байх хугацаандаа урьд хожид “Ололт 收获”, “Ардын утга зохиол”, “Аравдугаар сар 十月”, “Залуу зохиолчид 青年作家”, Шанхайн утга зохиол”, “Тал нутаг” гэх зэрэг сэтгүүл дээр зохиол бүтээлээ нийтлүүлж, анхдагч өгүүллэгийн түүвэр Тэнэг үнэг алга болсон нь 2002 онд хэвлэгдсэн юм. Түүний зохиол бүтээлийн тоо нь бага боловч зохиол бүтээлийнх нь хайр сэтгэл маш бялхам, уран гайхамшигт дүрслэн бодолттой мөртөө бичлэгийн арга нь өөрийн гэсэн хэв маягаар үе

* Өвөр Монголын Их Сургуулийн Монгол Судлалын Дээд Сургуулийн магистрант



THE CULTURAL WAY

тэнгийн зохиолчдоос ялгагдаж байдаг. Тэрээр Зургадугаар хугацааны хятад хэлний залуу зохиолчдын шагнал, Туужийн сонгомолын хоёрдугаар хугацааны Ши фү шян хундагат шинэ зохиолчийн шагнал, Арван нэгдүгээр хугацааны Дин Лин-ий нэрэмжит утга зохиолын шагнал, Хоёрдугаар хугацааны Тал нутаг утга зохиолын шагналын шинэ зохиолчийн шагнал, Арван наймдугаар хугацааны Аравдугаар сарын утга зохиолын шагнал гэх зэрэг шагналыг хүртсэн байдаг. Түүний “味火” гэх өгүүллэг нь дундад улсын өгүүллэгийн нийгэмлэгийн 2019 оны дундад улсын өгүүллэгийн жагсаалтад сонгогдож, 2020 оны Цэцэгт газрын утга зохиол (花地文学)-ын нэрсийн жагсаалтад оржээ. Ойрын жилүүдэд Чэнь Ганлун, Ань Нин, Линь Бэй, Ян Чиншян, Ше Шанфа гэх зэрэг зохиолч шүүмжлэгч эрдэмтдээс Дулааны өгүүллэг ба зохион бүтээлтийг нь адил бус талаас шинжлэн, хувь хүнийхээ үзэл үнэлэлтээ дэвшүүлсэн байдаг.

Тэнэг үнэг алга болсон нь гэх өгүүллэг хамгийн анх Ололт сэтгүүлийн 2019 оны №4 хугацаанд нийтлэгджээ. Тус өгүүллийг өрнө дахины золиосны хонь гэх ур загварын хувилбар хэмээн хэлж болно. Харь газрын үнэг (өгүүллэгийн гол баатар, зохиолд хятадаар 乌尼戈 гэснийг энд уг утгаар нь үнэг гэж монголчлов) аливаа хүчирхийлэл болон хөнөөлийг амсаж, тэнэг мунхаг болсны ард түүнийг гай барцад авч ирлээ хэмээн дур таваар шийтгэн яллаж, хөөрхий үнэг эцэстээ алагдсан байна. Үнэг хүчирхийлэл хөнөөл болон тэгш бус хувь заяаны эсрэг хорсож гомдсонгүй, үхлийн өмнө ч айн эмээж тэлчлээгүй билээ. Үхэл нь түүнийг нэг зүйлийн төгсгөлгүй амилал, үхэлгүй мөнхрөлд хүргэсэн байна. Өгүүллэгт зохиолын гол баатар үнэгний гурван удаагийн сураг тасарсан ба гурван удаагийн дахин илэрсэн гэх гол сэжмээр үлгэрийн үйл явдлыг хэлхэн холбож, үнэг гэгч золиосны хонины дүрийг зураглан бүтээсний хамт хүн чанарт нуугдаж байгаа муу муухай талыг илчилсэн байна. 20 дугаар зууны өрнө дахины алдарт онолч шүүмжлэгч Носров Фрей (诺思洛普·弗莱 1912-1991)-ийн үзэхээр, ур загвар гэдэг бол нийтлэг мөртөө дахин давтан илэрдэг санаа дүр (意象) мөн, утга зохиол нь шидэт үлгэрээс эх үүсэлтэй, шидэт үлгэрт хойч үеийн утга зохиолын хөгжлийн явц дахь аливаа хэлбэр ба гол сэдэв агуулагдаж байдаг. Тус өгүүлэлд Фрейн ур загварын онолыг ашиглан Дулааны Тэнэг үнэг алга болсон нь гэх өгүүллэгт илэрсэн золиосны хонины ур загварыг шинжлэн, энэхүү ур загварын ард нуугдсан хүн чанарын тухай асуудал, аль эсвэл энэ



өгүүллэгийн тусгах гэсэн утга санааны тухай өөрийн үзэл төрөгдлөө хуваалцъя.

Нэг. Золиосны хонь гэх ур загварын тухай

Золиосны хонийг англиар scapegoat гэдэг, бусдын орноос ял там амсах этгээдийг зүйрлэн заана. Энэ үгийн гарал нь Вильям Тиндале (William Tindale 1492-1576)-ийн 1525 онд грек хэлнээс орчуулсан Ариун номоос эхлэлтэй, золиослох өдөр (贖罪日)-т хүн төрөлхтний ял нүгэлийг үүрэглэсэн хонь, даруй өргөл тахилгад хэрэглэдэг хонийг заана. “Ариун ном, Ли мү жи 利未记”-ийн 16 дугаар бүлэгт, хонь ямааг тахилгад өргөхөөр өөрийн ял нүгэлээ цагаатгах тухай тэмдэглэл нэлээд олон бий. Бодитоор хэлбэл Мойсын хуулийн тогтоолыг үндэслэвэл, жил бүрийн золиослох өдөрт еврейчүүд хоёр хонь гаргаж, нэгийг нь тахилгын эд болгож хурмаст тэнгэрт өргөн, нөгөөг нь тахилын ширээн доор уяад, өнөөх хонины толгойг нь гараар доош дарна. Энэ нь хамаг амьтныг орлон хурмаст тэнгэрт энэ нэг жилийн ял нүгэлээ наминчилж байгааг төлөөлж, дахиад энэ золиосны хонийг эзгүй газарт хөөж явуулдаг юм. Иймээс Ариун номд тахилгын хонь ба золиосны хонь гэсэн хэллэгтэй болж, золиосны хонь гэх ур загвар ч үүнээс үүсэлтэй байдаг.

Үүнээс гадна, Ариун номын Шинэ гэрээнд тонолжин жясанд хүргэгдсэн Есүс мөн золиосны хонины гунигт хувь заяанаас мултарч чадаагүй. Түүний золиосны хонь болсон шалтгаан нь хүчирхийллийг чадахын чинээгээр хориглож, нэг хүний үрэгдлээр бүх улсыг аварсан хэмээн тайлбарлаж болно. Канадын шүүмжлэгч Н.Фрей “Аугаа их код Ариун ном хийгээд утга зохиол” гэх бүтээлдээ: “Есүс үнэндээ Хуучин гэрээ, Ли мү жи-д дурдсан ялаа золиох тахилга дээрх хоёр хонины үйлдийг ганцаар үүрэглэсэн байна” хэмээн зааж гаргажээ. Үүнтэй адилаар эртний грекийн шидэт үлгэр “Одипис” доторх гол баатар нь мөн ч золиосны хонины төлөөлөгч болох юм. Сахиусны зарлигийн өгүүлэхээр Одипис өөрийн эцгээ алж эхээ залган авч сууснаас болж Тибэ хотод хулганын хижиг дэлгэрэв гэж, түүний хувь хүний ял хилэнцээс болж олонд гай гамшиг авч ирсэн учраас зөвхөн Одиписыг шийтгэвэл сая бүх Тибэ хотыг аварч чадна. Энэ нь үнэндээ Одиписын ганц хүний үрэгдлээр бүх хотын амар төвшинг сольж байгаа явдал байж, яг ийм учраас Одиписын дүр нь золиосны хонь болсон нь гарцаагүй. Дээр дурдсан иймэрхүү ял нүгэл буюу гай барцадыг шилжүүлэх үйл ажиллагаа эртний нийгэмд маш



нийтлэг чанартай байжээ. Хүн судлалын эрдэмтэн Ж.Г.Фрейзэр (詹姆斯 乔治 弗雷泽 1854-1941) Алтан мөчир гэх номдоо, золиосны хонь гэх ухагдахууныг нарийн тайлбарласнаар барахгүй дэлхийн бүх газрын золиосны хонийг алахаар гай гамшгаас зайлах тахилгыг ч нарийн тэмдэглэсэн байдаг.

Иймэрхүү гай гамшгаас хэлтрэх бодит жишээ монголчуудын тууль хайлах ажиллагаанд мөн адилханаар оршиж байна. Жангарын бүх бүлгийг хайлдаггүй, хэрэв 12 бүлэг бүхнийг хайлбал үүдэн дээр нэг шар толгойт хонийг уяж тавиад, туулиа хайлж дуусмагц тэр хонийг даруйхан алах хэрэгтэй, эс тэгвэл Жангарчийн гэдэс нь дэлбэрэх аюултай” гэж Цогжин багшийн хээрийн шинжилгээний тэмдэглэлд байна. Жангарчийн бие дээрх гай барцадыг шар толгойт хонинд шилжүүлсэн учраас тэрхүү хонь нь золиосны хонь болсныг харуулна. Олны мэдэхээр, тууль хайлах нь гай гамшгийг арилгаж сайн сайхныг ерөөн бэлгэдэн, эзэд сахиусыг баясгах үйлдэлтэй байдаг. Саяын материалаас үзвэл тууль нь мөн ч хүн төрөлхтнийг залхаан шийтгэх чадамжтай юм. Энэ нь даруй юунд тууль хайлах үед заавал гарч мэдэх гай гамшгийг хонины бие дээр шилжүүлдэг гэдэг ёсыг тайлбарласан байна¹. Золиосны хониор ял нүгэл буюу аюул гамшгаас хэлтрэх үйл ажиллагаа нь өрнө дахин дорно дахинд нийтлэг оршдог. Энэхүү ялаа золиослох ажиллагаа нь хэдийгээр улиран хувьссан ч мөн л өнөөгийн зарим зан үйлд хадгалагдаж, нэг зүйлийн үл мэдэгдэх далд ухамсрын хувиар хүмүүсийн дотоод сэтгэлд гүн хадагджээ.

Харин золиосны хонь нь нэг зүйлийн уран зохиолын ур загвар болон хувьсаж, уран зохиолын чухал дүрслэгдэхүүн болж үе улиран хөгжсөөр иржээ. Золиосны хонины тухай ур загварын онолыг үүсгэгч нь Н.Фрей болно. Түүний үзэхээр, ур загвар гэдэг бол нийтлэг мөртөө дахин давтан илэрдэг санаа дүр мөн, ур загвар даруй анхны хэлбэр. Утга зохиолын анхны хэлбэр нь шидэт үлгэр, шидэт үлгэрт хойч үеийн утга зохиолын хөгжлийн явц дахь аливаа хэлбэр ба гол сэдэв агуулагдаж байдаг. Иймээс шидэт үлгэр бол ур загвар болох юм. Фрей-ээс ур загварын тухай тодорхойлолд шинэ тайлбар хийж, ур загварын онолыг нэг зүйлийн бодитжуулсан шүүмжлэлийн арга зам болгосон байна. Тэрээр ур загварын онолыг утга зохиолын хэмжээнд шилжүүлэн

¹ 阿婧斯：试论蒙古古诗讲唱中的‘替罪羊’现象，《内蒙古艺术学院学报》，2012年第3期9卷，p.120-121



хэрэглэж, шидэт үлгэрийн ур загвар болон утга зохиолын харьцааг судлахаар дамжин зохиол бүтээлийн жинхэнэ утга агуулгыг эрэлхийлсэн байна.

Хоёр. Тэнэг үнэг – золиосны хонь гэх ур загварын тайлал

Дулааны өгүүлэн буй өгүүллэгээс золиосны хонь гэх ур загварын дахин илрүүллийг олж харж болно. Доор тус өгүүллэгийн үйл явдал, дүр бүтээлт гэх хоёр талаас золиосны хонь гэх ур загварын дахин цогцлолт хийгээд дүрс хувиралтыг ажиглая.

Өгүүллэг зохиолын гол баатар тэнэг үнэгний 3 удаагийн сураг тасарсан ба 3 удаагийн дахин илэрсэн гэх гол сэжмээр үлгэрийн үйл явдлыг хэлхэн холбосон байдаг. Зохиол эхлэнгүүтээ “我的房客乌尼戈，在一个鼯鼠满世界跑的春季消失了。”² гэж үгүйсгэлийн хэлбэрээр гол баатраа татан гаргахын хамт үнэгний 1 дүгээр удаагийн сураг тасарсныг тунхаглажээ. Тэгээд үнэгний хэрхэн би-ийн гэрт ирсэн, балгасны ардын тэнэг үнэгэнд дургүйцсэн ба цаашлан янз бүрийн аргаар үнэгийг хардсан тухай бичсэн байна. “远处突然传出了惨叫... 随着达林台的痛击，乌尼戈逐渐呼吸困难，脸色发青，指甲发紫。他开始拼命吸气，却被达林台的弯刀割断了喉咙！”³ тэнэг үнэг ингэж Далантайн хутган доор амиа алдав. Ийнхүү гол баатрын үхэл нь 2 дугаар удаагийн сураг тасарсныг харуулжээ. Үнэгний үхсэнийг нүдээр харсан “би” ч эмнэлэгт орж, “би” мэс заслаа хийгээд эмнэлгээс гэртээ буцахад, үнэг гэрийн үүдэн дээр “би”-г хүлээж байв. Энэ нь гол баатрын дахин амилал бөгөөд дахин илрэл болно. Гэвч дахин амилсан тэнэг үнэг угийн өнгө төрхөө алдсан байна: “乌尼戈身上发生了一些变化。他无法维持漂亮男孩的形态，他总是白发苍苍，脸孔黑得像岩石。”⁴ балгасны ард мөн л цөхрөшгүйгээр тэнэг үнэгийг шийтгэн яллаж, тэнэг үнэг ч аливаа хүчирхийлэл болон хөнөөлийг амсаж явжээ. Балгасны ардаас солонго арвидаж, гай гамшиг үүссэнийг тэнэг үнэгийн яршиг хэмээн хөөн, тэдний тэнэг үнэг дэх хүчирхийлэл нь ч оргилдоо тулж, “乌尼戈被这群疯子拉到广场上，当着众人的面被毫无人道地注射了硫磺妥钠，当场变成了无数片齿状的娇叶，被一股脑儿地塞进了火化炉里。”⁵ ингэж тэнэг үнэг үнс болон замхарч,

² 渡澜：傻子乌尼戈消失了，北京十月文艺出版社，2022年，p. 1

